

Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлын судалгааны тайлан - 2024

АГУУЛГА

Бүлэг 1. Удиртгал	6
1.1. Үндэслэл	6
1.2. Судалгааны зорилго, зорилт.....	6
1.3. Судалгааны арга зүй	6
1.4. Судалгааны түүвэр, хамрах хүрээ	8
Бүлэг 2. Тоон судалгаа	9
2.1. Судалгаанд оролцогчдын мэдээлэл	9
2.2. Цахим дайралтын талаарх сэтгүүлчийн мэдлэг, ойлголт	10
2.3. Сэтгүүлчид цахим дайралтад өртсөн эсэх.....	12
2.4. Цахим дайралтын хэлбэр, төрөл, агуулга	20
2.5. Цахим дайралтын эрсдэл, үр нөлөө	23
2.5. Тоон судалгааны дүгнэлт, зөвлөмж	31
Бүлэг 3. Кейс шинжилгээ	33
3.1. Сонгогдсон кейсийн ерөнхий мэдээлэл	33
3.2. Кейс шинжилгээ-1.....	34
3.3. Кейс шинжилгээ-2.....	35
3.4. Кейс шинжилгээ-3.....	38
Бүлэг 4. Хууль, эрх зүйн орчны судалгаа.....	43
4.1. Хууль зүйн асуудал	43
4.2. Өнөөгийн нөхцөл байдал	45
4.3. Сэдвийн судлагдсан байдал.....	46
4.4. Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчинг сайжруулах санал зөвлөмж	47
5. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж	49
Ашигласан материалын жагсаалт.....	51
Хавсралт 1. Санал асуулгын хуудас	52

Хүснэгт, Зургийн Жагсаалт

Зураг 1. Судалгаанд оролцогчдын нас, хүйс	9
Зураг 2. Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн туршлага, салбар	9
Зураг 3. Цахим дайралтын талаар мэддэг эсэх.....	10
Зураг 4. Цахим дайралтын талаар мэддэг эсэх, насны бүлгээр.....	10
Зураг 5. Цахим дайралтын талаар мэддэг эсэх, хүйсээр	11
Зураг 6. Цахим дайралтын талаарх ойлголт, тодорхойлолт.....	11
Зураг 7. 2020-2024 оны хооронд ямар нэгэн байдлаар цахим дайралтад өртсөн эсэх, хүйсээр	12
Зураг 8. 2020-2024 оны хооронд ямар нэгэн байдлаар цахим дайралтад өртсөн эсэх, насны бүлгээр	13
Зураг 9. Цахим дайралтад өртсөн байдал ажилладаг салбараар	13
Зураг 10. Цахим дайралтад өртсөн байдал ажилласан жилийн туршлагаар.....	14
Зураг 11. Цахим дайралтад өртсөн давтамж, хүйсээр	14
Зураг 12. Цахим дайралтад өртсөн давтамж, насны бүлгээр.....	15
Зураг 13. Цахим дайралтад өртсөн суваг, хүйсээр	16
Зураг 14. Цахим дайралтад хариу өгсөн байдал, хүйс, насны бүлгээр.....	16
Зураг 15. Цахим дайралтад хариу өгсөн байдал ажилласан жилээр.....	17
Зураг 16. Цахим дайралтын эх үүсвэр	17
Зураг 17. Цахим дайралтын эх үүсвэр, хүйсээр	18
Зураг 18. Цахим дайралтын эх үүсвэр ажилладаг салбараар.....	19
Зураг 19. Цахим дайралтын газар зүйн байршил.....	19
Зураг 20. Цахим дайралтын зөрчлийн хэлбэрүүд	20
Зураг 21. Сэтгүүлчдэд ирсэн цахим дайралтууд	21
Зураг 22. Цахим дайралтууд, хүйсээр	22
Зураг 23. Цахим дайралтын эрсдэл	23
Зураг 24. Цахим дайралт арга хэмжээ авсан эсэх	25
Зураг 25. Хуулийн дагуу арга хэмжээ авсан хүмүүс насны бүлгээр	26
Зураг 26. Авсан арга хэмжээ	26
Зураг 27. Дайралтад өртөөд авсан арга хэмжээ, хүйсээр	27
Зураг 28. Дайралтад өртөөд авсан арга хэмжээ, насны бүлгээр.....	27
Зураг 29. Цахим дайралтын дараа тусламж, дэмжлэг авсан байдал.....	28
Зураг 30. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өөрийгөө цензурдэж байсан эсэх, насны бүлгээр	29
Зураг 31. Цензурийн илрэл	29
Зураг 32. “Өөрийн цензур”-ын хамгийн нийтлэг хортой үр дагавар	30
Зураг 33. Кейс-1.....	34
Зураг 34. Кейс-2.....	35
Зураг 35. Кейс-2. Цаг хугацааны дараалал	36
Зураг 36. Кейс-2. Нэвтүүлгийн сэтгэгдлийн жишээ	37
Зураг 37. Кейс-2. Нэвтрүүлгийн сэтгэгдлийн жишээ	37
Зураг 38. Кейс-3.....	39
Зураг 39. Кейс-3. Сэтгэгдлүүд	39

Зураг 40. Кейс-3. Нэвтрүүлэг	40
Зураг 41. Кейс-3. Хувь хүний хаягийн жишээ	40
Зураг 42. Кейс-3. Нэвтрүүлгийн рейкшин жишээ.....	41
Зураг 43. Кейс-3. Хувь хүний хаягийн жишээ	41
Зураг 44. Сэтгүүлч рүү ирсэн дайралтын анализ.....	42

Хүснэгт 1. Цахим дайралтын агуулга	23
Хүснэгт 2. Цахим дайралтын үр нөлөө, сэтгэл санаа бие махбодын	24
Хүснэгт 3. Цахим дайралтын үр нөлөө, гэр бүлд	24
Хүснэгт 4. Цахим дайралтын эдийн засгийн үр нөлөө.....	25
Хүснэгт 5. Цахим дайралтын үр нөлөө, найз нөхдөд	25
Хүснэгт 6. Сайн дурын байгууллагад хандсан байдал	28
Хүснэгт 7. Сэтгүүлчийн аюулгүй байдлын тухай олон улсын ангилал.....	47

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТҮХ	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХМЗ	Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

Бүлэг 1. Удиртгал

1.1. Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр (АТҮХ)-ийн Зорилго 3-т Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ гэж тусгасан ба тус зорилгын дагуу хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилт тавьсан. Энэ хүрээнд АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөний 3.4.4.4 Сэтгүүлчдийн аюулгүй байдлын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлох судалгаа, хяналт-шинжилгээ хийх ажлыг тусгасан.

Тус арга хэмжээний хүрээнд сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг сайжруулах, хангахын тулд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ)-өөс энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ. Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг авч үзэхийн тулд ажил мэргэжилтэй холбоотойгоор цахим орчинд ямар нэгэн дайралтад өртөж буй эсэхийг авч үзсэн. Үүнд заналхийлэл, сүрдүүлэг, дарамт, шахалт, доромжлол зэргийг багтаана.

1.2. Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь сэтгүүлчдийн цахим аюулгүй байдлын талаарх мэдлэг ойлголт, сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхдээ цахим орчинд ямар нэгэн дайралтад өртөж буй эсэх цахим дайралт, гутаан доромжлолын талаар тодруулах, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах хууль эрх зүй, зохицуулалтын орчинг судлах, цаашид хэрхэн шийдвэрлэх боломж, шийдлийг тодорхойлоход оршино.

Тус зорилгын хүрээнд дараах дэд сэдвүүдийг судалгааны зорилт болгон дэвшүүлж авч үзсэн. Үүнд:

- Сэтгүүлчдийн цахим дайралтын талаарх ойлголт, үүнд өртөж буй байдал
- Цахим дайралтын хэлбэр, давтамж, агуулга, нөлөө
- Цахим дайралтын эсрэг авч буй хариу арга хэмжээ
- Бодит кэйсүүдэд тулгуурласан шинжилгээ
- Хууль, эрх зүйн зохицуулалт

1.3. Судалгааны арга зүй

Монголын сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар өмнө нь судлагдсан байдал болон олон улсад судалсан байдал зэргийг харгалзан үзэж сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг судалж, өнөөгийн нөхцөл байдлыг тодрууллаа. Дараах тоон болон чанарын судалгааны аргыг сэтгүүлчдийн цахим аюулгүй байдлын судалгаанд хослуулан гүйцэтгэсэн. Үүнд:

Тоон судалгааны арга: Улс төр, нийгэм, эдийн засгийн чиглэлээр ажилладаг (ажиллаж байсан) сэтгүүлчдийн цахим аюулгүй байдлын талаарх мэдээллийг санал асуулгын судалгааны аргаар судалж тоон үр дүнг гаргасан. Тоон судалгаагаар дараах асуултуудын хүрээнд мэдээлэл цуглуулсан. Үүнд:

- Цахим дайралтын талаарх сэтгүүлчдийн мэдлэг ойлголт ямар байна?
- Сэтгүүлчийн ажил мэргэжилтэй холбоотойгоор сүүлийн 3 жилд цахим орчинд ямар нэгэн дайралт /заналхийлэл, сүрдүүлэг, дарамт, шахалт, доромжлол/-д өртөж байсан уу?
- Цахим орчинд ямар нэгэн дайралтад өртсөн бол ямар хэлбэрийн дайралт, хэдэн удаагийн давтамжтай, ямар хугацаанд өртсөн бэ?
- Тус дайралт ямар сувгаар, хэнээс, хаанаас ирсэн бэ?
- Цахим дайралт ямар агуулгатай байсан? (үндэс угсаа, нийгмийн гарал, арьс өнгө, шашин шүтлэг, бие мах бод, ажил мэргэжлээр нь ялгаварлан гадуурхсан, гутаан доромжилсон, нэр хоч өгсөн, үзэн ядан үг хэллэг ашигласан эсэх гэх мэт)
- Цахим дайралт өртсөн сэтгүүлчийн газар зүйн байршил, нас, хүйсийн хувьд онцлог ялгаа байна уу?
- Цахим дайралтад өртсөн үедээ хариу арга хэмжээ авдаг эсэх? Ямар хариу арга хэмжээ авдаг, дэмжлэг, туслалцаа хүсдэг эсэх?
- Цахим дайралтад өртсөнөө баримтжуулж баталгаажуулдаг эсэх, хаана, хэнд ханддаг вэ?
- Сэтгүүлчийн аюулгүй байдлын эрх зүйн орчинг сайжруулахад талаар санал зөвлөмж

Чанарын судалгаа арга: Сэтгүүлч цахим дайралтад өртсөн тодорхой гурван кейсийг сонгон авч тухайн дайралтад өртсөн жишиг, тохиол дээр контент анализын аргаар мэдээлэл цуглуулж зардлан шинжилсэн. Цахим дайралтад өртсөн олны анхааралд өртсөн гурван сэтгүүлчийн кейсийг сонгон авч тухайн тохиол дээр социал медиа мониторингийн аргаар мэдээлэл цуглуулж чанарын шинжилгээ хийсэн. Үүнд:

- Хэн? (социал медиа хэрэглэгчийн хаягийн төрөл) ямар хариу үйлдэл үзүүлж байна (хариу, үйлдлийн хэлбэр)?
- Хариу үйлдлийн хандлага (эерэг, сөрөг, саармаг)
- Хариу үйлдлийн агуулга ямар байна? (сэтгэгдлийн агуулга нь үндэс угсаа, нийгмийн гарал, арьс өнгө, шашин шүтлэг, бие мах бод, ажил мэргэжлээр нь ялгаварлан гадуурхсан, гутаан доромжилсон, нэр хоч өгсөн, үзэн ядан үг хэллэг ашигласан эсэх гэх мэт) зэрэг тухайн кейсд үзүүлж буй цахим мэдээллийн хэрэгсэл хэрэглэгчдийн хариу үйлдлийг нарийвчлан судалсан. Мөн тухайн кейстэй холбоотой өгөгдлийг зургаар баримтжуулж тайланд оруулсан.

Баримт бичгийн судалгаа: Цахим орчин дахь сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой хууль зүйн асуудал, өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой өмнө хийгдсэн бусад судалгаа, тайлан, бичиг баримтуудыг судалж цаашид авч хэрэгжүүлж болох эрх зүйн зохицуулалтын санал зөвлөмж өгсөн.

1.4. Судалгааны түүвэр, хамрах хүрээ

Хамрах хүрээ:

Сүүлийн гурван жилд (2022 оны 01 сараас 2024 оны 10 сар хүртэл) сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагад мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэсэн сэтгүүлч, уран бүтээлчдийг энэхүү судалгаанд хамруулсан. Чанарын судалгааны судлагдахуун болсон кейсүүд нь 2022 оны 01 сараас 2024 оны 09 сард болж өрнөсөн кейсүүдээс сонгосон.

Түүвэр:

1. Тоон судалгааны түүвэр:

Сүүлийн 3 жилд ямар нэгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилласан (ажиллаж байсан, одоо ажиллаж буй) 300 сэтгүүлчийг (сэтгүүлч, сурвалжлагч, зураглаач, тоймч, редактор, эрхлэгч гэх мэт) асуулгын судалгаанд хамруулсан.

2. Чанарын судалгааны түүвэр:


Цахим дайралтад өртсөн гурван сэтгүүлчийн кейс (жишиг, тохиол)-т сошиал мониторинг хийв. Кейсийг сонгох гол шалгуур нь цахим орчинд олон хүний санаа бодол, сэтгэгдлийн бай болсон, цахим мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчийн мэтгэлцээний индэр болсон, хүмүүсийн анхаарлыг ихээхэн татсан кейсүүдийг сонгосон.

Бүлэг 2. Тоон судалгаа

2.1. Судалгаанд оролцогчдын мэдээлэл


Тоон судалгаанд нийт 300 сэтгүүлчийг хамруулсан бөгөөд судалгааны анхдагч мэдээллийг нягтлан шалгаж боловсруулалт, дүн шинжилгээ хийв. Нийт судалгаанд оролцогчдын 76% нь эмэгтэй, 24% нь эрэгтэй сэтгүүлчид байна. Насны бүлгийн хувьд нийт оролцогчдын 16% нь 18-25 насны сэтгүүлчид, 26-35 нас 31%, 36-45 нас 32%, 46-55 насныхан 16%, 56 ба түүнээс дээш насны сэтгүүлчид 4%-ийг эзэлж байна.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын нас, хүйс



Оролцогчдын ажилласан жилийн туршлагын хувьд 10-15 жил ажилласан туршлагатай сэтгүүлчид хамгийн их буюу 21%, түүний дараа 1-3 жил ажилласан сэтгүүлчид 20%, бусад бүлгийн хувьд харьцангуй ойролцоо буюу арав гаруй хувьтай байна. Харин ажиллаж буй салбарын хувьд мэдээллийн сайтад ажилладаг сэтгүүлч 37%, телевизэд ажилладаг сэтгүүлчид 32%-ийг эзэлж байна.


Зураг 2. Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн туршилага, салбар



2.2. Цахим дайралтын талаарх сэтгүүлчийн мэдлэг, ойлголт


Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 31% нь цахим дайралтын талаар сайн мэднэ гэж хариулсан бол 63% нь тодорхой хэмжээнд мэднэ гэж хариулжээ. Харин 6% нь энэ талаар бараг мэдэхгүй гэжээ. Үүнээс харахад нийт оролцогчдын дийлэнх нь өөрсдийгөө цахим дайралтын талаар тодорхой хэмжээнд мэддэг гэж үзэж байна.

Зураг 3. Цахим дайралтын талаар мэддэг эсэх




Оролцогчдын хариултыг насны ангиллаар авч үзвэл сайн мэднэ, тодорхой хэмжээнд мэднэ гэж хариулсан сэтгүүлчдийн дийлэнх буюу 67% нь 26-45 насныхан байгаа ба 18-25 насны бүлэг 14%, 46-55 нас 15%, 56 ба түүнээс дээш насны хүмүүс 4%-ийг эзэлж байна. Тодорхой хэмжээнд мэднэ гэж хариулсан оролцогчдын хувьд мөн адил 26-45 насныхан хамгийн их буюу 62% ба 18-25 насны залуу сэтгүүлчдийн хувь нэмэгдэж 19% болсон бол 46-55 нас 15%, 56-аас дээш насныхан 3%-ийг эзэлж байна. Харин хэлж мэдэхгүй байна гэж хариулсан сэтгүүлчдийн 64%-ийг 26-35 насны хүмүүс, үлдсэн хувь нь 46-аас дээш насны бүлгийн сэтгүүлчид байна. Үүнээс харахад хэдийгээр бүх насны бүлгийн сэтгүүлчид тодорхой хэмжээнд мэдлэгтэй гэж хариулж байгаа ч, залуусын хувьд ялгаатай буюу цөөн хувь нь өөрсдийгөө цахим дайралтын тухай ойлгож, мэдэж байгаа эсэх ээ хэлж мэдэхгүй, эргэлзээтэй гэж үзэж байна.

Зураг 4. Цахим дайралтын талаар мэддэг эсэх, насны бүлгээр




Харин хүйсээр авч үзвэл, эмэгтэй сэтгүүлчид өөрсдийгөө энэ талаар илүү мэддэг гэж үзсэн байна.

Зураг 5. Цахим дайралтын талаар мэддэг эсэх, хүйсээр



Цахим дайралтын тухай ойлголтыг тодруулахад 84% нь өгөгдсөн хариултын сонголтууд бүгдийг цахим дайралтад тооцно гэж үзсэн байгаагаас оролцогчдын ойлголт сайн байгааг харуулж байна. Зөвхөн 2% нь хариулж мэдэхгүй байна гэсэн бол 4% нь өгөгдсөн сонголтуудаас өөр бусад тодорхойлолтыг хэлнэ гэж үзсэн байна.

Зураг 6. Цахим дайралтын талаарх ойлголт, тодорхойлолт



Оролцогчдын хариултыг хүйсээр авч үзвэл эмэгтэй оролцогчдын 82% нь, эрэгтэй оролцогчдын 64% нь дээрх бүх хэлбэрийг цахим дайралт гэж үзнэ гэсэн байна.


Бусад гэж сонгосон оролцогчдын хувьд өөрсдийн ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Санаатайгаар гуйвуулсан мэдээллийг цахимаар санаатайгаар түгээх, хэн нэгэн, эсвэл хэсэг бүлэг хүмүүс, зорилтот бүлэг, ард иргэдийн эсрэг зохион байгуулалттайгаар программчилсан, нэг талыг барьсан, мэдээллээр дарангуйлахад чиглэгдсэн мэдээллийг бэлтгэн түгээх
- Хэн нэгнийг ажил хөдөлмөр, гэр бүлтэй нь хамааруулж олны дунд эвгүй байдалд оруулах
- Сэтгүүлчид бодит мэдээлэл бэлтгэн түгээснийхээ төлөө эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүсийн цахим дайралт, доромжлолд өртдөг
- Мэдээлэл, дата хулгайлах
- Бусдын хаягийг санаатайгаар хакердахыг хэлнэ
- Платформыг ажиллагааг санаатай зогсоох
- Хэн нэгний тухай зохион байгуулалттайгаар хуурамч хаягнаас мэдээлэл түгээх
- Хувийн account руу нэвтрэх, хувийн мэдээллийг авч түүгээр дарамталж сүрдүүлэх
- Санаатай тараасан мэдээ, сэтгүүлчийн эсрэг сөрөг мэдээлэл

2.3. Сэтгүүлчид цахим дайралтад өртсөн эсэх


Судалгаанд оролцогчдоос 2020-2024 оны хооронд цахим дайралтад өртсөн эсэхийг асуухад нийт оролцогчдын 54% нь үгүй, 40% нь тийм гэж хариулсан бол 6% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна. Бараг хоёр оролцогч тутмын нэг нь өнгөрсөн 4 жилийн хугацаанд цахим дайралтад өртөж байсан гэж хариулсан байгаагаас харахад энэ нь сэтгүүлчдэд түгээмэл тохиолдож байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэй оролцогчдын 44%, эмэгтэй оролцогчдын 38% нь өртөж байсан гэж хариулсан байна.

Зураг 7. 2020-2024 оны хооронд ямар нэгэн байдлаар цахим дайралтад өртсөн эсэх, хүйсээр




Насны бүлгээр авч үзвэл 36-45 насныхны 50% нь, 46-55 насныхны 49% нь, 26-35 насныхны 35% нь цахим дайралтад өртсөн гэж хариулсан байна. Харин 18-25 насныхны хувьд 24% нь, 56-аас дээш насныхны 22% нь өртөж байсан байна. Үүнээс харахад цахим дайралтад өртсөн хүмүүсийн дийлэнх нь 26-45 насны бүлэгт хамаарч байгаа буюу тал хувь нь өртсөн байна.

Зураг 8. 2020-2024 оны хооронд ямар нэгэн байдлаар цахим дайралтад өртсөн эсэх, насны бүлгээр



Цахим дайралтад өртөж байсан эсэхийг ажилладаг салбараар авч үзвэл сонин сэтгүүл, телевиз, мэдээний сайтад ажилладаг сэтгүүлч нарын бараг тал хувь нь өртөж байсан байна. Харин чөлөөт сэтгүүлчдийн 36% нь өртөж байсан бол радиогийн сэтгүүлчдийн 13% нь өртөж байсан гэж хариулжээ.


Зураг 9. Цахим дайралтад өртсөн байдал ажилладаг салбараар



Цахим дайралтад өртсөн байдлыг ажилласан жилээр авч үзвэл ажилласан жил нэмэгдэхийн хэрээр, тухайлбал 10-аас дээш жилийн туршлагатай сэтгүүлчид цахим дайралтад илүү өртдөг буюу сэтгүүлчдийн туршлагатай холбоотой байгаа нь ажиглагдаж байна. 15-20 жил ажилласан хүмүүсийн 53% нь, 10-15 жил ажилласан хүмүүсийн 49% нь, 20 болон түүнээс дээш жил ажилласан хүмүүсийн 47% нь цахим дайралтад өртсөн гэжээ. Харин 1-3 жил ажилласан хүмүүсийн 28%, 4-7 жилийн туршлагатай хүмүүсийн 30%, 7-10 жил ажилласан


хүмүүсийн 25% нь цахим дайралтад өртсөн гэж хариулсан байгаа нь бусад бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй бага байна.

Зураг 10. Цахим дайралтад өртсөн байдал ажилласан жилийн туршилагаар



Цахим дайралтад өртсөн давтамжийн хувьд судалгаанд оролцогчдын тал нь буюу 55% нь 1-3 удаа өртсөн гэж хариулсан байна. Оролцогчдын хүйсээр харвал 1-3, 4-6 удаа өртсөн хүмүүсийн хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү байгаа бол 7-10 удаа болон 10-аас дээш удаа өртсөн цахим дайралтад өртсөн оролцогчдын дунд эрэгтэйчүүдийн хувь илүү өндөр болж (12% болон 16%), эмэгтэйчүүдийн хувь харьцангуй бага буюу 6% болон 4% байна.


Зураг 11. Цахим дайралтад өртсөн давтамж, хүйсээр



Насны бүлгийн хувьд 1-3 удаа цахим дайралтад өртсөн хүмүүсийн дийлэнх нь 36-45 насныхан буюу 46%, дараа нь 26-35 насныхан 29% байна. 4-6 удаа өртсөн хүмүүсийн хувьд 36-45 нас болон 46-55 насныхан ижил 35% байна. 7-10 удаа өртсөн хүмүүсийн хувьд 36-45 насныхан 43%, 26-35 насныхан 29%-тай давамгайлж байна. Харин 10-аас дээш удаа өртсөн оролцогчдын ихэнх нь 26-35 насныхан 43%, дараа нь 18-25, 56-аас дээш насныхан 14%

байна. Ерөнхийдөө, цахим дайралтад өртөх хандлага залуу болон ид ажиллах насныханд илүү өндөр байна.


Зураг 12. Цахим дайралтад өртсөн давтамж, насны бүлгээр



Цахим дайралтад өртсөн оныг асуухад 2022 онд хамгийн их цахим дайралтад өртсөн гэж хариулсан байна. 2022 онд өртсөн гэж оролцогчдын 45% нь хариулсан бол дараа нь 2024 онд гэж 35% нь хариулсан байна. 2020-2021 оны хооронд өртсөн гэж 24% болон 29% нь хариулсан бол, 2023 онд хамгийн бага буюу 23% нь байна. Ерөнхийдөө сүүлийн жилүүдэд цахим дайралтад өртөх байдал улам нэмэгдэж байгаа нь харагдаж байгаа ба 2020-2021 оны хооронд Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотойгоор идэвх бага, 2024 оны хувьд сонгуулийн жил байсантай холбоотойгоор илүү идэвхжсэн байх магадлалтай юм.

Цахим дайралт ирсэн, дайралтад өртсөн сувгийн хувьд Фэйсбүүкийн пост 81% болон чат 56% хамгийн их хувийг эзэлж байгаа бол и-мэйлээр гэсэн хариулт хамгийн бага хувийг эзэлж байна. Өртсөн сувгийг хүйсээр авч үзвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь Фэйсбүүкийн пост (31% эрэгтэй, 39% эмэгтэй) болон Фэйсбүүкийн чат (26% эрэгтэй, 25% эмэгтэй)-аар хамгийн их цахим дайралтад өртсөн байна.


Зураг 13. Цахим дайралтад өртсөн суваг, хүйсээр



Нийт сувгийн төрлийг харвал эмэгтэйчүүд арай өргөн хүрээнд буюу олон сувгаар өртсөн болох нь харагдаж байна.

Цахим дайралт ирсэн тухайн платформд хариу арга хэмжээ авсан эсэхэд оролцогчдын 74% нь үгүй, 26% нь тийм гэж хариулсан байна. Хариу арга хэмжээ авсан байдлыг хүйс болон насаар авч үзвэл эмэгтэй оролцогчдын 28% нь, эрэгтэй оролцогчдын 21% нь байна. Насны бүлгүүдээс 36-45 насныхан хариу арга хэмжээ авсан хүмүүс дотор хамгийн их хувь буюу 58%-ийг эзэлж байна.


Зураг 14. Цахим дайралтад хариу өгсөн байдал, хүйс, насны бүлгээр



Хариу өгсөн байдлыг ажилласан жилийн туршлагаар харвал 10-аас дээш жил ажилласан хүмүүс илүүтэй хариу өгсөн гэж хариулсан байна. Хамгийн их хувийг 20 ба түүнээс дээш жил ажилласан хүмүүс буюу 33% эзэлж байна. Ажилласан жил ихсэх тусам дайралтад хариу өгөх буюу илүү туршлагатай болж байх магадлал ажиглагдаж байгаа ба нөгөө талаас


туршлага бага, шинэ сэтгүүлчдийн хувьд энэ талаарх ойлголт, туршлага хязгаарлагдмал байх магадлалтай юм.

Зураг 15. Цахим дайралтад хариу өгсөн байдал ажилласан жилээр



Цахим дайралтын эх үүсвэр буюу хаанаас ирсний хувьд хамгийн их хувь нь жирийн иргэд 38% эзэлж байна. Үүний дараа хэн гэдгийг нь тодорхой хэлж мэдэхгүй, мөн нийгмийн цөөнх (Үндэсний цөөнх, ЛГБТ хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт) гэсэн хариултууд адилхан 27%-тай байлаа. Эдгээрээс гадна Засгийн газар, улс төрчдөөс гэж 18% нь, урлаг соёл олны танил хүмүүсээс гэж 13% нь, бизнесмэн, нөлөө бүхий этгээдээс гэж 12% нь хариулжээ.



Зураг 16. Цахим дайралтын эх үүсвэр



Насны бүлэг, хүйсийн ангиллаар авч үзвэл социал медиад олон дагагчтай нөлөөлөгчдөөс ирэх дайралт эрэгтэйчүүдэд өндөр, бусад бүх эх үүсвэрүүдэд эмэгтэйчүүд илүү хувьтай

хариулсан байна. Тухайлбал жирийн иргэдээс, урлаг, соёл, олны танил хүмүүсээс ирэх дайралт эмэгтэйчүүдэд харьцангуй өндөр байна. Насны ангиллын хувьд залуучуудад нийгмийн цөөнх, жирийн иргэд, олны танил хүмүүсээс, дунд насныханд тодорхой бус эх үүсвэр, бизнес эрхлэгчид, улс төрийн зүгээс ирсэн дайралт илүү байна.


Зураг 17. Цахим дайралтын эх үүсвэр, хүйсээр



Ажилладаг салбарт бас багагүй ялгаа байгаа нь сонин, сэтгүүлд ажилладаг сэтгүүлчид засгийн газар, улс төрчдөөс гэж хариулсан хувь илүү, телевизийн сэтгүүлчид жирийн иргэдээс, нийгмийн цөөнхөөс гэж, мэдээллийн сайтад ажилладаг сэтгүүлчид сошиал медиад


олон дагагчтай инфлүнсэрүүдээс гэж хариулсан байдал их хувьтай байгаагаас харагдаж байна.

Зураг 18. Цахим дайралтын эх үүсвэр ажилладаг салбараар



Цахим дайралт газар зүйн байршлын хувьд гадаад улсаас, хилийн чанадаас ирсэн гэж хариулсан хувь хамгийн өндөр буюу 38%, дараа нь хөдөө орон нутгаас ирсэн дайралт 36%, нийслэл хотоос ирсэн дайралт 23%, хаанаас ирснийг тодорхойлох боломжгүй гэсэн 22% байлаа. Үүнээс харахад цахим дайралт зөвхөн дотоодын буюу Монгол Улсад оршин сууж буй хэрэглэгчдээс давсан, хилийн чанадаас ирж байгаа нь гадаадад байдаг хэрэглэгчээс гадна тролл хаяг, хуурамч гадны хаягууд байх магадлал бий нь ажиглагдаж байна. Мөн хөдөө орон нутагт бас цахим дайралт хийх хувь багагүй, нийслэл хотоос өндөр хувьтай байгаа нь анхаарал татаж байна.


Зураг 19. Цахим дайралтын газар зүйн байршил



2.4. Цахим дайралтын хэлбэр, төрөл, агуулга

Цахим дайралт ирсэн зөрчлийн хэлбэрүүдийг тодруулахад нийт оролцогчдын талаас илүү хувь буюу 53% нь үзэн ядсан, заналхийлсэн үг хэллэгээр дайрах хэлбэрт өртөж байсан байна. Түүний дараа хуурамч мэдээлэл тараах байдлаар буюу гүжир, гүтгэлэг 47%, дараа нь хуурамч сэтгэгдэл, реакшнуудаар дайрах 45% буюу зохион байгуулалттай дайралтуудыг харуулж байна. Цахим халдлага 26% – хакердах, аккаунт руу нэвтрэх оролдлого багагүй байна. Хувийн гэрэл зураг, дүрсийг зөвшөөрөлгүй тараах 13%, үл мэдэгдэх мессэж ирэх 13%, амь насанд заналхийлсэн 13% байгаагаас харахад шууд хувь хүн, амь насанд нь халдахаар заналхийлэх тохиолдлууд багагүй байна. Бие махбодид халдахаар заналхийлсэн 9%, тагнах, чагнах 6%, бэлгийн дарамт 4%, таныг тодотгох хувийн мэдээллээ алдах 3%, бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхийг заналхийлсэн 3% буюу харьцангуй цөөн байгаа ч хамгийн аюултай хэлбэрүүдээр үйлдэгдсэн тохиолдлууд бийг харуулж байна.

Зураг 20. Цахим дайралтын зөрчлийн хэлбэрүүд




Эдгээр хэлбэрүүдийг хүйсээр харьцуулан харвал бага зэргийн ялгаатай байдлууд ажиглагдаж байна. Эмэгтэйчүүдийн хувьд түгээмэл тохиолдсон хэлбэрүүд нь, бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхийг заналхийлсэн 100%, энэ нь зөвхөн эмэгтэйчүүд ийм заналхийлэлд өртсөн, эрэгтэй сэтгүүлчид өртсөн гэж хариулаагүй, бэлгийн дарамт 75% буюу эрэгтэйчүүдээс гурав дахин өндөр хувьтай, үл мэдэгдэх мессэж ирэх 83% буюу тодорхойгүй мессэжүүд эмэгтэйчүүдэд илүү ирдэг, гүтгэлэг, гүжирдлэг 74% буюу эмэгтэйчүүд энэ төрлийн дайралтад эрэгтэйчүүдээс гурав дахин их өртөж байна. Мөн

хуурамч сэтгэгдэл, реакшнуудаар дайрах 75%, үзэн ядсан, заналхийлсэн үг хэллэгээр дайрах 77%, тагнах, чагнах 80%, цахим халдлага 65% байна. Эрэгтэйчүүдийн хувьд, таныг тодотгох хувийн мэдээллээ алдах 100%, амь насанд заналхийлсэн хэлбэр 58% буюу эрэгтэйчүүдэд чиглэсэн амь насанд аюул учруулах заналхийлэл эмэгтэйчүүдээс арай илүү хувьтай өртсөн байна.

Сэтгүүлчдэд ирсэн цахим хүчирхийлэл, дайралтуудын төрлийг тодруулахад, хувь хүн рүү дайрах: Бусад төрлийн хараалын үг зэргээр дайрах, доромжлох төрлөөр 59% хамгийн өндөр хувьтай, дараа нь мэргэжлийн нэр хүндэд халдах 58%-тай байна. Ихэнх хүмүүст хувь хүнд чиглэсэн дайралт, нэр хүндэд халдах хоёр хамгийн түгээмэл байгааг харуулж байна. Дараа нь хүйсээр ялгаварлан гадуурхах, эмэгтэй хүн гэдгээр нь дайрах дайралт 26%-тай байна. Хүйсийн хувьд дайралтуудад бага зэргийн ялгаа байгаа нь өмнөх үр дүн, үзүүлэлтүүдээс ч мөн адил ажиглагдсан. Үүний дараа улс төрийн үзэл баримтлалаар итгэл үнэмшлээр нь дайрах тохиолдол 19%-тай байна. Бусад хувь хүн рүү дайрсан, заналхийлсэн, итгэл үнэмшил рүү дайрсан төрлүүд харьцангуй бага хувьтай буюу 10%-иас бага хувьтай тохиолдсон байна.


Зураг 21. Сэтгүүлчдэд ирсэн цахим дайралтууд



Хүйсээр ангилж үзэхэд бэлгийн хүчирхийлэл заналхийлэл, гэр бүл, ойр дотны хүрээлэлд нь халдах заналхийлэл, хүйсээр ялгаварлан гадуурхах, мэргэжлийн нэр хүндэд халдах, хараал доромжлолын үг илүү хувьтай байгаа бол ижил хүйстэн гэж доромжлох нь 100%

эрэгтэйчүүдэд тохиолдож байна. Арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлах нь аль алинд ижил 50%-тай байна.

Зураг 22. Цахим дайралтууд, хүйсээр



Цахим хүчирхийлэл, дайралтад өртсөнөө ямар нэгэн байдлаар баталгаажуулж, баримтжуулж байсан эсэхийг тодруулахад 60% нь үгүй, 13% нь санахгүй байна гэж хариулсан бол дөнгөж 26% нь тийм гэж хариулсан.

Сэтгүүлчдэд ирсэн цахим дайралтын агуулгыг тодруулахад гадна төрх, гадаад үзэмж, хувь хүний царай зүс, хүйсээр доромжилж, хувь хүнрүү чиглэж дайрч доромжилж, хараадаг, хувийн нэр хүндэд халддаг. Худлаа инээсэн, хуурамч хүүхэн, тэнэг сэтгүүлч, чи эмэгтэй учраас ийм тэнэг байгаа юм, эцгээрээ мөнгө олох гэсэн хүүхэн, мөнгөний хүүхэн, гичий гэх мэт янз бүрээр нэр хоч өгөх, хараалын үгээр доромжилсон, хувь хүний гадаад төрх, хүйсээр дайрсан гэсэн тохиолдол хамгийн их буюу 27%-тай байна. Түүний дараа мэдээллийг нуун дарагдуулахыг хүсдэг, мэдээллээ устгахыг шаардах, мэдээллээ засаж, өөрчил гэж шаарддаг, хамтран ажилладаг хүмүүсээр яриулах, нөлөөлөхийг янз бүрийн аргаар оролддог, дээд албан тушаалтан, туршлагатай ажиллагсдаар дарамтлуулж, хавчих, үг хэлээр доромжлох гэх мэт хийж буй ажил руу дайрах тохиолдол 21%-тай байна. Хэдийгээр эзлэх хувь бага байгаа

хэдий ч бусад агуулга нь амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, дарамталсан, аюултай хэмжээнд байна.


Хүснэгт 1. Цахим дайралтын агуулга

№	Цахим хүчирхийлэл, дайралтын агуулга	Тоо	Хувь
1	Гадна төрх, гадаад үзэмж, хувь хүний царай зүс, хүйсээр доромжилж, хувь хүнрүү чиглэж дайрч доромжилж, хараадаг, хувийн нэр хүндэд халддаг. Худлаа инээсэн, хуурамч хүүхэн, тэнэг сэтгүүлч, чи эмэгтэй учраас ийм тэнэг байгаа юм, эцгээрээ мөнгө олох гэсэн хүүхэн, мөнгөний хүүхэн, гичий гэх мэт янз бүрээр нэр хоч өгөх, хараалын үгээр доромжилдог	51	27%
2	Мэдээллийг нуун дарагдуулахыг хүсдэг, мэдээллээ устгахыг шаардах, мэдээллээ засаж, өөрчил гэж шаарддаг, хамтран ажилладаг хүмүүсээр яриулах, нөлөөлөхийг янз бүрийн аргаар оролддог, дээд албан тушаалтан, туршлагатай ажиллагсдаар дарамтлуулж, хавчих, үг хэлээр доромжлох гэх мэт	39	21%
3	Нэр хаяггүй тролл, бот хаягаас зориудаар харлуулах, гүтгэх, доромжлох, бэлтгэсэн мэдээний дор нэрээ нууж байнга доромжилсон коммент бичдэг, олон нийтийн сүлжээнд гүтгэдэг, доромжилдог, дайрдаг, нүцгэн зураг, бичлэг чинь байгаа группүүдээр дэлгэнэ шүү гэж дарамталдаг, пост, сторигоор тааглаж доромжилдог	36	19%
4	Аятайхан байгаарай, амьд явахыг чинь, сайн явахыг чинь харнаа, араа харж яваарай, танай гэр, ажил хаана байдаг вэ? ална шүү, эрэмдэг болгоно шүү, амь насанд чинь халдана шүү, хоолгүй болгоно, ажилгүй болгоно гэх мэтээр айлган сүрдүүлж, заналхийлдэг. Залхаадаг, утасны дугаар руу шөнө, орой залгадаг. 7 жил үргэлжилж байна.	21	11%
5	Сэтгэл зүй, сэтгэл санаанд дарамт учруулж, айдаст автуулдаг, сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргадаг, гэр бүлийн хүний чинь талаар яриа гаргана гэж сүрдүүлэх гэх мэт	21	11%
6	Шантаажчин, улс төрчдийн гар хөл гэх мэтээр мэргэжлийн нэр хүндэд халдсан үг хэлээр доромжилдог, гүтгэдэг, дайрдаг	18	10%
	Нийт	186	100%

2.5. Цахим дайралтын эрсдэл, үр нөлөө

Цахим дайралтын эрсдэлийг асуухад сэтгэл санаа, бие махбодын эрсдэл хамгийн өндөр байна. Судалгаанд оролцогчдын 42% нь эрсдэл өндөр, 41% нь дундаж, 17% нь бага эрсдэлтэй гэж үзсэн байна. Үүний дараагийн эрсдэл нь гэр бүлд нөлөөлсөн эрсдэлийг 24% нь өндөр, 33% нь дундаж, 37% нь бага гэж үзсэн байна. Харин эдийн засгийн эрсдэл харьцангуй бага гэж хариулсан байгаа хэдий ч мэдэхгүй гэж хариулсан нь өмнөх хоёр эрсдэлээс арай өндөр хувьтай байгааг харахад, цахим дайралтаас үүдэлтэй аливаа эрсдэл, хохирлыг сэтгүүлчид эдийн засгийн хувьд хэмжих боломжгүй байгааг харуулж байна.

Зураг 23. Цахим дайралтын эрсдэл



Цахим дайралтад өртсөнөөр гарсан үр нөлөөг харахад хувь хүний хувьд айдас түгшүүр, сэтгэл гутрал, стресс зэрэг сөрөг үр дагаврууд хамгийн олон, түүний дараа нэр хүндээ алдах, ажлаас гарах, сэтгүүл зүйн ажлаас татгалзах зэрэг ажил, карьерт сөргөөр нөлөөлсөн үр нөлөөнүүд гарсан байна. Үүнээс цахим хүчирхийлэл, дайралт нь хувь хүний ажил хөдөлмөр эрхлэх чадварыг бууруулах, сэтгэл зүйн хямрал, гутралд оруулж байна.

Хүснэгт 2. Цахим дайралтын үр нөлөө, сэтгэл санаа бие махбодын

№	Цахим дайралтын үр нөлөө	Тоо	Хувь
1	Сэтгэл санаанд нөлөөлж, сэтгэлээр унаж, гутарч, айдас түгшүүртэй болсон. Сэтгэл гутралд орсон. Ганцаараа явахаас айдаг болсон. Гайхаж цочирдсон, тайван байдлаа алдсан. Тавгүйтэж хямарсан, стрессдсэн. Сэтгэл санаагаар унаж, мэргэжлээс халшрах шинж тэмдгүүд илэрсэн, Айх, сандрах мэдрэмж төрсөн. Нийгмийн мэдээллийн сүлжээнд зургаа оруулахаас айдаг болсон. Дуугаа хураасан, сонсдог дуугаа сонсох дургүй болж амьдралын идэвхгүй болсон.	74	68%
2	Мэдээллийн эх сурвалжаа алдсан, урам хугарч, ажлын идэвх санаачилга алга болсон, ажлаасаа гарсан. Сэтгүүл зүйн салбарт ажиллах итгэл буурсан. Нойргүйдсэн. Доромжлогдож, буруу ойлгогдож, гүтгэгдсэндээ хямарч машин барьж чадахаа байх гэх мэт чаддаг үйлдлээ хийж чадахгүй болтлоо хямарсан. Нэр хүндээ алдсан. Дахиж тийм төрлийн мэдээ, мэдээлэл бэлтгэхээс зайлсхийх байдал ажиглагдаж байсан. Өөрийн цензурийг өөртөө бий болгосон. Ажлын бүтээмжээ алдсан.	24	22%
3	Одоо дөжирч, тоохоо больсон, тролл, бот хаягуудыг блоколдог болсон.	8	6%
4	Тоогоогүй өнгөрсөн учраас нөлөө үзүүлсэн эсэхийг мэдэхгүй байна.	4	4%
Нийт		108	100%

Гэр бүлийн байдалд гарсан үр нөлөөний хувьд мөн адил сэтгэл санааны хямралд орох, эцэг, эхийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, ажлаас гарах, өөр ажил хийхийг санал болгох зэрэг үр нөлөөнүүд илэрч байсан байна. Үүнээс харахад цахим дайралт нь зөвхөн хувь хүнд сөрөг нөлөөтэйгээс гадна ойр дотны хүмүүст бас сөргөөр нөлөөлж байна. Хамгийн хурц хэлбэр нь гэр бүлийн хүний ажилд шалгалт оруулсан тохиолдол гарсан байна.

Хүснэгт 3. Цахим дайралтын үр нөлөө, гэр бүлд

№	Цахим дайралтын үр нөлөө	Тоо	Хувь
1	Гэр бүлийнхэнд хүндээр нөлөөлсөн, гэр бүлийн гишүүд эрдэлээс айсан. Хамт сэтгэл санаагаар унасан. Айж түгшсэн. Эцэг, эх сэтгэл санааны дарамтад орсон. Аав, ээжийн даралт ихэсдэг болсон. Гэр бүлийнхэн ажлаа хийхийг болихыг санал болгох, нийгмийн хурц асуудлаар сэтгүүлчийн байр сууринаас ажиллахгүй байхыг санал болгож байсан.	21	49%
2	Гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлсөн, нөхрийн шүүмжлэлд өртөх, ойр дотныхон доромжлох, муулах хандлагатай байсан. Сэтгэл санаа тав тухгүй байснаас гэр бүлийнхээ давхар хохирч дам байдлаар нөлөөлсөн.	13	30%
3	Нөлөөлөл байхгүй	6	14%
4	Гэр бүлийн санхүүгийн байдалд нөлөөлсөн. Гэр бүлийн хүний ажилд нь шалгалт оруулсан гэх мэт	3	7%
Нийт		43	100%

Эдийн засгийн хувьд гарсан нөлөөг авч үзвэл бизнесийн үйл ажиллагаа түр зогссон, бизнесийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлсэн учир хамтран ажиллагч байгууллагуудаа алдсан, орлогогүй болсон, цалингийн торгуулийн арга хэмжээ авсан, ажлаас гарч цалингүй болсон зэрэг сөрөг үр дагаврууд учирсан байна.

Хүснэгт 4. Цахим дайралтын эдийн засгийн үр нөлөө

№	Цахим дайралтын үр нөлөө	Тоо	Хувь
1	Бизнесийн үйл ажиллагаа түр зогссон, бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн, ивээн тэтгэгч олдохоо больсон, дэмжигч, хамтрагч байгууллагууд гэрээгээ цуцалсан.	17	31%
2	Ажлаас гарсан тул орлогогүй болсон. Ажлаасаа чөлөө авсан, хөндийрсөн тул орлогогүй болсон.	12	22%
3	Цалингийн арга хэмжээ авхуулсан тул бодит орлого муудсан. Шинэ санаачилга байхгүй болсноор нэмэлт орлого олох ажлууд буурсан. Мэргэжлийн ажлаасаа олох орлого буурсан.	11	20%
4	Эрсдэл, нөлөөлөл байхгүй	9	16%
5	Бие муудсаны улмаас өөрт болон гэр бүлд санхүүгийн асуудал гарсан.	6	11%
Нийт		55	100%

Цахим дайралтын улмаас найз нөхдөд гарсан нөлөөний хувьд асууж шалгаах, эргэлзэх, уулзахаас татгалзах, хамтарч ажиллахгүй байх, ажлаас гарахыг санал болгох зэрэг сэтгүүлчид дам нөлөө үзүүлж байсан бол найз нөхдөд нь бас дайралт ирэх, доромжлох, хамт сэтгэл санаагаар хохирох явдлууд ч мөн адил тохиолдож байжээ.


Хүснэгт 5. Цахим дайралтын үр нөлөө, найз нөхдөд

№	Цахим дайралтын үр нөлөө	Тоо	Хувь
1	Найз, нөхөд гайхсан, байнга асууж, шалгаж байсан, уулзахыг хүсэхгүй байсан. Хамтран ажиллахаас татгалзсан. Ажлаа болихыг санал болгосон. Найз нөхдийн зүгээс нэр төрд халдаж байсан.	12	36%
2	Ямар нэгэн нөлөөлөл байхгүй.	8	24%
3	Найзууд руу хэд, хэдэн удаа бичиж доромжилж, хамт сэтгэл санаагаар хохироосон. Найз нөхөд мөн сэтгэл санаагаар унасан. Зарим найзууд дэмжиж байсан.	7	21%
4	Хамтран ажилладаг зарим найзууд баярхаж, басамжилж, тохуурхаж байсан. Больчих орхичих, эвлэрчих, миний таньдаг хүн байгаа юм битгий нийтэл гэх мэт санал тавьж байсан. Орон нутагт төрийн байгууллагад ажиллахыг хориглосон.	6	18%
Нийт		33	100%

Цахим дайралтын эдгээр нөлөөллүүдийг харвал энэ нь зөвхөн хувь хүний сэтгэл санаа, ажил орлого, эдийн засаг, карьерт сөрөг нөлөө үзүүлэхээс гадна нийгмийн харилцаанд алсуур нөлөөлөх, нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдөх, дэмжлэг авах, хамтран ажиллах байдалд давхар сөрөг нөлөө авчирч байна.


Цахим дайралтад өртөөд хуулийн дагуу арга хэмжээ авсан эсэхэд судалгаанд оролцсон сэтгүүлчдийн бараг гуравны нэг орчим буюу 32% нь арга хэмжээ авсан, тал нь буюу 51% нь авч байгаагүй, 17% нь хэлж мэдэхгүй гэсэн байна. Үүнээс харахад дайралтад өртсөн сэтгүүлчдийн дийлэнх нь арга хэмжээ авдаггүй, аль эсвэл авч мэдэхгүй байх магадлалтай байна.

Зураг 24. Цахим дайралт арга хэмжээ авсан эсэх



Хуулийн дагуу арга хэмжээ авсан хүмүүсийн насны ангиллыг харахад залуучууд болон ахмад сэтгүүлчид арга хэмжээ аваагүй эсвэл хамгийн бага авсан, дунд насны хүмүүс илүү арга хэмжээ авсан байна.


Зураг 25. Хуулийн дагуу арга хэмжээ авсан хүмүүс насны бүлгээр



Харин хүйсийг харвал арга хэмжээ авсан хүмүүсийн дийлэнх нь буюу 62% нь эмэгтэйчүүд, 38% нь эрэгтэйчүүд байна. Ажиллаж буй салбарын хувьд цахим дайралтад өртдөг салбараа дагаад сонин, сэтгүүл, телевиз, мэдээллийн сайтад ажилладаг сэтгүүлчид арга хэмжээ авсан хувь нь арай өндөр, чөлөөт сэтгүүлчид огт авч байгаагүй байна.

Арга хэмжээ авсан хүмүүсийн хувьд ямар арга хэмжээ болохыг тодруулахад редакц, удирдлагадаа хандсан хувь нь хамгийн өндөр буюу 41%, дараа нь найз нөхөд, гэр бүл ойр дотны хүнд хандсан гэсэн хариулт 33%-ийг эзэлж байна.


Зураг 26. Авсан арга хэмжээ



Үүнээс харахад ихэнх нь албан байгууллага болон хувийн хүрээлэлдээ хэлдэг бол хуулийн байгууллага, өмгөөлөгчид хандах явдал бага хувьтай, нийтлэг биш байна. Хүйсээр харвал


бүх үзүүлэлтүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хувьтай байгаа хэдий ч зөвхөн хуулийн байгууллага, Засгийн газрын харьяа байгууллагад хандсан гэсэн хариултын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс арай илүү байна. Үүнээс харахад эрэгтэйчүүд албан ёсны байгууллагад илүү ханддаг байна.

Зураг 27. Дайралтад өртөөд авсан арга хэмжээ, хүйсээр



Насны ялгааг харвал залуу болон дунд насныхан өмгөөлөгчид илүү хандсан, сэтгүүлчийг хамгаалах сайн дурын байгууллагад залуу (26-35) болон ахимаг насныхан (46-55) илүү хандсан. Залуу болон дунд насныхан редакц, удирдлагадаа хандсан байна.

Зураг 28. Дайралтад өртөөд авсан арга хэмжээ, насны бүлгээр



Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах ямар нэгэн сайн дурын байгууллагад хандсан хүмүүсээс хаана, хэзээ хандсан болохыг тодруулахад Глоб Интернэшнл төв ТББ-д хандсан тохиолдол хамгийн олон давтамжтай байна. Түүний дараа Хүний эрхийн үндэсний комисст хандсан тохиолдлууд орж байна.


Хүснэгт 6. Сайн дурын байгууллагад хандсан байдал

№	Хэзээ	Хаана хандсан	Давтамж
1	2020 онд	Хүний эрхийн үндэсний комисст хандсан	1
2	2021 онд	Иргэдийн шударга шүүх ТББ-д хандсан	1
3	2021 онд	МСНЭ-ийн хуульчид хандсан	1
4	2022 онд	Глоб Интернэшнл ТББ-д хандсан	2
5	2023 онд	Глоб Интернэшнл ТББ-д хандсан	2
6	2024 онд	Глоб Интернэшнл ТББ-д хандсан	1
7	2024 онд	Хүний эрхийн үндэсний комисст хандсан	1
Нийт			9

Засгийн газрын харьяа байгууллагад хандсан тохиолдлуудын хувьд харьяа дүүргийнхээ цагдаагийн байгууллагад хандсан гэсэн 4 хариулт, Харилцаа холбооны Зохицуулах Хороонд мэдэгдсэн гэж 1 хүн хариулсан байв.


Цахим дайралтын дараа авсан тусламж, үйлчилгээ, дэмжлэгийн хувьд судалгаанд оролцогчдын 79% буюу ихэнх нь ямар ч дэмжлэг, тусламж аваагүй байна. Авсан хүмүүсийн хувьд сэтгэл зүйн дэмжлэг, аюулгүй байдлын тухай сургалт, зөвлөмж авсан байна.

Зураг 29. Цахим дайралтын дараа тусламж, дэмжлэг авсан байдал




Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өөрийгөө цензурдэж байсан эсэхийг асуухад нийт судалгаанд оролцогчдын 61% нь тийм, 17% нь үгүй гэж хариулсан бол 22% нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Үүнийг хүйсээр харвал эмэгтэй сэтгүүлчдийн 65% нь, эрэгтэй сэтгүүлчдийн 46% нь тийм гэж хариулсан байна. Насны бүлгийг харвал өөрийгөө цензурдэж байсан гэсэн хүмүүст 36-45 насныхан хамгийн их буюу 34%, дараа нь 26-35 насныхан 29%, 18-25 насныхан 19%, 46-55 насныхан 17%, 56 ба түүнээс дээш насныхан 1% эзэлж байна.

Зураг 30. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өөрийгөө цензурдэж байсан эсэх, насны бүлгээр




Хэрэв тийм бол цензур нь өөрт ямар шинжээр илэрдэг вэ гэсэн асуултад тал хувь нь үзэгч, уншигчдаас зэмлэл, шүүмжлэл ирнэ гэж бодсон гэж үзсэн байна. Мөн эрхлэгч, редактороос зэмлэл, шүүмжлэл ирнэ гэж бодсон 36%, эздээс дарамт, шахалт, хүсэлт ирнэ гэж бодсон 28% байна.

Зураг 31. Цензурийн илрэл



Энэхүү цензур, илэрсэн шинжүүдийн хортой үр дагаврын хувьд сэтгүүлчийн ур чадвар, зориг мөхнө гэж 48% нь үзсэн байна. Мөн ирээдүйдээ итгэл алдарч сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулахаас татгалзаж эс үйлдэхүйд хөтөлнө, олон нийтийн ашиг сонирхлыг хойш тавина гэсэн хариултууд удаалж байна. Үүнээс харахад эдгээр нь сэтгүүлчдийн ажил мэргэжил ээ эрхлэх байдалд нэг талаар хориг болох, үүнээс улбаалан иргэдийн мэдээлэл авах хүртээмж багасах эрсдэлийг харуулж байна.

Зураг 32. “Өөрийн цензур”-ын хамгийн нийтлэг хортой үр дагавар



Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн зүгээс цаашид сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг хамгаалах, сэтгүүлчийн өөрийн цензурыг бууруулахтай холбоотой саналыг асуухад Хэвлэл мэдээллийн хууль, эрх зүйн орчинг сайжруулах, шинэчлэх, сэтгүүлч эх сурвалжаа нууцлахыг хуульчлах, Цахим аюулгүй байдлын тухай хуулийг чангатгах, Эрүүгийн хуулийн 13.14-ийг нэн даруй хуулиас хасах, хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд үр дүнтэй хариуцлага тооцдог болох, сэтгүүлчийн гэр, ажлын байр, машинд зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр нэгжлэг хийдэг болгох гэх мэт хууль эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой саналууд хамгийн олон давтагдсан нь байв. Түүний дараа редакцийн хараат бус байдлыг хангах, редакцын чадавхийг өсгөх, редакцууд “хаалтын гэрээ” гэгддэг онцгой хүсэлттэй гэрээ хийхгүй байх, редакцын ёс зүйг төлөвшүүлэх, редакцууд сэтгүүлчээ хамгаалах гэсэн редакцын зүгээс сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой сайжруулалтууд орж байна. Мөн сэтгүүлчдийг сургалтад хамруулах, мэргэшүүлэх хөгжүүлэх, чадавхжуулах, суралцах нөхцлийг бүрдүүлэх, эрх зүйн мэдлэгтэй болгох зэрэг сэтгүүлчдийн өөрсдийн аюулгүй байдлаа хангах чадамжийг сайжруулахтай холбоотой саналууд түгээмэл давтагджээ.

№	Цахим хүчирхийлэл, дайралтын агуулга	Тоо	Хувь
1	Хэвлэл мэдээллийн хууль, эрх зүйн орчинг сайжруулах, шинэчлэх, сэтгүүлч эх сурвалжаа нууцлахыг хуульчлах, Цахим аюулгүй байдлын тухай хуулийг чангатгах, Эрүүгийн хуулийн 13.14-ийг нэн даруй хуулиас хасах, хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд үр дүнтэй хариуцлага тооцдог болох, сэтгүүлчийн гэр, ажлын байр, машинд зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр нэгжлэг хийдэг болгох гэх мэт	100	25%
2	Редакцийн хараат бус байдлыг хангах, редакцын чадавхийг өсгөх, редакциуд хаалтын гэрээ хийхгүй байх, редакцын ёс зүйг төлөвшүүлэх, редакцууд сэтгүүлчээ хамгаалах	59	15%
3	Сэтгүүлчдийг сургалтад хамруулах, мэргэшүүлэх хөгжүүлэх, чадавхуулах, суралцах нөхцлийг бүрдүүлэх, эрх зүйн мэдлэгтэй болгох	54	14%
4	Мэргэжлийн ёс зүйтэй байх, баримтыг нягтлах, мэргэжлийн түвшинд ажиллах, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх	30	8%

5	Мэдээллийн эрх чөлөөг олгох, мэдээллийг авахад саад бэрхшээл учруулахгүй байх, мэдээлэл өгөх эрх бий байгууллагыг улам нээлттэй болгох, мэдээллийн эх сурвалжийг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн салбар дахь төрийн оролцоог бууруулах	29	7%
6	Мэргэжлийн байгууллага, холбоод сэтгүүлчээ бодитоор хамгаалдаг болох, сэтгүүлчийг хамгаалах механизм бий болгох, шаардлагатай тохиолдолд сэтгүүлчийг хамгаалах, өмгөөлөх	26	7%
7	Цахим орчинг хязгаарлах, хуурамч хаягуудыг устгах, хяналт сул байна, троллуудын эсрэг арга хэмжээ авах	19	5%
8	Олон нийтийг соён гэгээрүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хэвлэл мэдээлэлд итгэх иргэдийн итгэлийг сайжруулах	17	4%
9	Сэтгүүлчид өөрсдөө цахим аюулгүй байдлаа хангаж сурах, түүнд суралцах	16	4%
10	Хэлж мэдэхгүй, тодорхой санал байхгүй, өөрийн цензур гэж юу болохыг мэдэхгүй байна.	16	4%
11	Өөртөө цензур тавихгүй байхыг редакцын дотоод журмаар зохицуулах, өөрийн цензураас ангид байх арга, туршлагыг нэмэгдүүлэх	11	3%
12	Сэтгүүлчийн ажлын нөхцлийг сайжруулах, ажиллах тухтай орчинг бүрдүүлэх, цалин, хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны баталгааг бий болгох	8	2%
13	Бусад	6	2%
14	Сэтгүүлчид өөрсдөө цензуртай байх нь зөв ёс зүйгээ баримтална, мэргэжлийн ажиллана	4	1%
Нийт		252	100%

2.5. Тоон судалгааны дүгнэлт, зөвлөмж

Сэтгүүлчдийн бараг тал орчим хувь нь цахим дайралтад өртөж байсан ба энэ нь сэтгүүлчдэд хувь хүний болон нийгмийн харилцаа руу халих түвшинд хүртлээ сөргөөр нөлөөлөх хэмжээнд очсон байна.

Цахим дайралтын хэлбэр, төрлийн хувьд фэйсбүүкийн пост, коммент хамгийн нийтлэг хэдий ч хувь хүний харилцах суваг болох чат, мессэжээр илүү хурц дайралт, заналхийлэл ирдэг байна. Агуулгын хувьд гутаан дормжилсон үг хэллэг, гүтгэлэг хамгийн түгээмэл бөгөөд хүйсийн бага зэрэг ялгаатай буюу эмэгтэй сэтгүүлчдийн гадаад үзэмж, төрх зэрэг хувь хүнрүү нь чиглэсэн дайралт эрэгтэйчүүдээс их байдаг байна. Мөн эмэгтэйчүүдэд бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх заналхийлэл ирдэг гэсэн нь сэтгүүлчдийн ажил мэргэжилтэй холбоотойгоор жендэрт суурилсан хүчирхийлэл үүсэх эрсдэлтэйг харуулж байгаа ба хэдийгээр бага хувьтай ч анхаарууштай явдал юм. Эрэгтэй сэтгүүлчдийн хувьд амь насанд заналхийлсэн дайралт эмэгтэйчүүдээс арай илүү тохиолддог гэсэн ба энэ нь мөн л жендэрийн ялгаатай байдлаас үүдэлтэй нь харагдаж байна. Мөн зөвхөн эрэгтэй сэтгүүлчдэд тохиолдсон гутаан доромжлолын нэг хэлбэр нь ижил хүйстэн гэж хэлэх явдал байсан нь сэтгүүлчдэд жендэрийн хэвшмэл ойлголтоос үүдэлтэй дайралтууд ирдэг болохыг харуулж байна.

Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн хувьд цахим дайралтын талаарх ойлголт, мэдлэг тодорхой хэмжээнд байгаа ба цахим дайралтыг хүлээн авах, хариу арга хэмжээ авсан байдал зэрэг нь сэтгүүлчдийн нас, хүйс болон ажиллаж буй салбарын онцлог бага зэрэг хамааралтай, янз бүр байна. Залуучууд болон ахмад насны бүлгийнхэн ямар арга хэмжээ авах, давж туулах хэлбэр зэрэг нь бусад насны бүлгээс арай хомс, хохирсон бол арга хэмжээ бараг авдаггүй байна. Хариу арга хэмжээ авч буй байдалд мөн хүйсийн ялгаатай хандлага ажиглагдсан нь эмэгтэй сэтгүүлчид түлхүү арга хэмжээ авсан гэж хариулсан байдлаас харагдаж байв. Залуучууд огт хариу арга хэмжээ аваагүй, дунд насныхан илүү идэвхитэй олон янзын арга хэмжээ авдаг, ахимаг насныхан илүүтэй сайн дурын байгууллагад ханддаг

зэргээс харахад сэтгүүлчдийн ажлын туршлага, настай холбоотойгоор цахим дайралтын тухай мэдлэг ялгаатай байгааг харуулж байна.

Цаашид хууль эрх зүйн орчин, цахим орчинд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах талаар хууль эрх зүйн зохицуулалтаас гадна редакцыг чадавхжуулах шаардлагатай байгааг сэтгүүлчид дурдсан байна.

Мөн судалгааны үр дүнгээс харахад сэтгүүлчдэд цахим дайралтын тухай мэдлэг ойлголтыг өгөх, хэрхэн хариу арга хэмжээ авах, хаана хандах, эрсдэлээс сэргийлэх зэрэг нарийвчилсан ойлголтуудаар хангах, ингэхдээ насны бүлгүүдийг харгалзан хамгийн туршлага багатай шинэ, залуу сэтгүүлчдэд илүүтэй анхаарах шаардлагатай байна. Үүнээс гадна хүйсийн ялгаатай байдал, жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой эрсдэл, нөлөөнүүдийг давхар таниулах, хүйсийн ялгаатай байдлаас болж өртөх эрсдэлээс сэргийлэх хэрэгцээ байгаа нь харагдлаа.

Цаашид сэтгүүлчид ажил мэргэжилтэйгээ холбоотойгоор хувь хүний доромжлол, гүтгэлэгт өртөх эрсдэлийг бууруулахад олон нийтийн цахим хэрэглээний тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн цахим орчны ерөнхий мэдлэг, соёлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг мөн давхар хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Бүлэг 3. Кэйс шинжилгээ

3.1. Сонгогдсон кейсийн ерөнхий мэдээлэл

Сэтгүүлч цахим дайралтад өртсөн тодорхой гурван кейсийг сонгон авч тухайн дайралтад өртсөн жишиг, тохиол дээр контент анализын судалгааны аргаар чанарын анализ хийлээ. Тодруулбал ямар нэгэн цахим дайралтад өртсөн гурван сэтгүүлчийн кейсийг сонгон авч тухайн тохиолдол бүрт сошиал медиа мониторингийн аргаар мэдээлэл цуглуулж дараах байдлаар чанарын шинжилгээг хийж гүйцэтгэв.

Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлын санал асуулгын мэдээлэл бүрдүүлэлтийн явцад асуудал хөндсөн, эрэн сурвалжилсан бүтээлийг тогтмол бэлтгэдэг, нийгмийн мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа фэйсбүүкээр дамжуулан олон нийтэд бүтээлээ хүргэдэг, бүтээлийн хандалт, сэтгэгдэл, реакшн ихтэй, цахим орчинд идэвхтэй сэтгүүлчийг сонгон авч 2022-2024 онд цахим дайралтад өртсөн тохиолдолд гүнзгийрүүлсэн ярилцлага хийж тохиолдсон кэйсүүдийг түүвэрлэн авав. Эдгээр тандалтад тулгуурлан кэйс судалгааг “Ньюсрүүм мэдээллийн төв” сайтын үүсгэн байгуулагч, сэтгүүлч Б.Батцэцэг, “Нууц материал” нэвтрүүлгийн сэтгүүлч С.Будрагчаа нарт тохиолдсон цахим аюулгүй байдлын зарим тохиолдолд дүн шинжилгээ хийлээ.

Сэтгүүлч Б.Батцэцэг нь 2010 оноос хойш асуудал хөндсөн, баримт, эрэн сурвалжилсан нэвтрүүлгүүдийг бэлтгэж ирсэн. Ийгл телевизэд “Бодит байдал”, NTV телевизэд “Тэгээс тэг” асуудал хөндсөн, эрэн сурвалжилсан нэвтрүүлгүүдийг бэлтгэж байсан. Тэрээр нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлуудыг сурвалжилж, асуудал хөндсөн, эрэн сурвалжилсан нэвтрүүлгүүдийг бэлтгэж олон нийтэд хүргэдэг.

2023 онд түүний бэлтгэсэн Боловсролын зээлийн сангийн тухай эрэн сурвалжилсан цуврал бүтээл нь эрэн сурвалжлах сэтгүүлзүйн “Цахиур” наадмын шилдэг бүтээлээр шалгарсан.

Түүний хувьд 2010 оноос хойш сэтгүүлчийн ажлыг хийж байх хугацаандаа бие махбодийн болон цахим дайралт, сүрдүүлэгт хэд, хэдэн удаа өртөж байсан. Тухайлбал, 2018 онд түүнийг Монгол, Туркийн хамтарсан сургуулийн захирал Вэйсел Акчейг хулгайлагдсан үйл явдлыг сурвалжилж байхад түүний биед эрүүгийн цагдаагийн төлөөлөгч биед нь халдаж, шанаа руу нь цохисон нь телевизийн камерийн дуранд бичигдсэн юм. Энэхүү үйл явдлын дараагаар Ийгл телевиз (сэтгүүлчийн ажиллаж байсан байгууллага) Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэл, Глоб Интернэшнл төв байгууллагууд сэтгүүлчийн аюулгүй байдалд халдсан асуудлаар мэдэгдэл гаргаж байсан.

Энэ удаагийн судалгаанд 2023-2024 онд түүнд тохиолдсон аюулгүй байдлын хоёр кэйсийг хамруулсан. Сэтгүүлчид тохиолдолд буй түгээмэл дайралт, аюулгүй байдлын зөрчлийн хэлбэр, суваг, болон дайралт, зөрчлийн эсрэг ямар нэгэн хариу хэмжээ авсан эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

3.2. Кейс шинжилгээ-1

Эхний кейс: Утсаар амь насанд заналхийлсэн тохиолдол


Сэтгүүлч Б.Батцэцэг нь Хар тугалгаар бохирдсон ус, тариалангийн талбай Монголчуудад эрсдэл дагуулж байна! Сэдвээр 27 минутын эрэн сурвалжилсан нэвтрүүлгийг бэлтгэж, “Сэтгүүлч Б.Батцэцэг” нэртэй фэйсбүүк хуудсандаа 2024.12.12-нд нийтэлжээ. Тус нэвтрүүлгээр Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг хаягдал аккумулятор боловсруулах “Цэлмэг хөх овоо” ХХК, Налайх дүүргийн дөрөвдүгээр хороонд үйл ажиллагаа явуулах “Болор Аграмба” ХХК-ийн үйлдвэрийн нөхцөл байдлыг сурвалжилсан. Нэвтрүүлэгт тус үйлдвэрүүд нь хаягдал аккумуляторыг стандартын бус аргаар боловсруулсны улмаас хар тугалга агаарт, хөрсөнд шингэж буйг сурвалжилж, мэргэжлийн эх сурвалжуудын байр суурь, дүгнэлтээр бататгасан байна.

Тус нэвтрүүлгийн фэйсбүүк хуудас дахь үзэлт 756 мянга, 2800 реакшн, 328 сэтгэгдэлтэй байна.

Сэтгэгдлийг шүүж үзэхэд нэвтрүүлэгт дурдагдсан кампанийн үйл ажиллагаанд дургүйцлээ илэрхийлсэн нь түгээмэл байв. Мөн сэтгүүлчийн ажлыг үзэгчийн зүгээс эерэгээр үнэлсэн сэтгэгдэл цөөнгүй байв.

Сэтгүүлч амь насанд заналхийлсэн утасны дуудлагыг нэвтрүүлэг цацагдсанаас 3 хоногийн дараа буюу 2024.12.15-нд хүлээн авсан. Уг заналхийллийг нэвтрүүлэгт дурдагдсан хаягдал аккумулятор боловсруулах “Цэлмэг хөх овоо” ХХК, “Болор Аграмба” ХХК-ийн зүгээс ирсэн гэж сэтгүүлч үзэж байна. Учир нь тухайн асуудлыг сурвалжлахгүй байхыг сануулсан.

Зураг 33. Кейс-1



Утсаар ирсэн заналхийллийг сэтгүүлч редакцияа, хүний эрхийг хамгаалах төрийн, төрийн бус, олон улсын байгууллага, засгийн газрын харьяа байгууллага болон эрх бүхий хууль хяналтын байгууллагад мэдэгдээгүй. Мөн өөрийн ажиллаж буй редакцын удирдлагадаа мэдээлээгүй байна.

Түүнээс энэхүү зөрчлийн талаар ямар нэгэн хариу арга хэмжээ аваагүй шалтгааныг тодруулахад эрэн сурвалжилсан сэтгүүл зүйн бүтээлийн дараагаар утсаар ямар нэгэн заналхийлэл, сүрдүүлэг, дарамт ирэх нь түгээмэл учир тоолгүй орхисон гэв. Түүнчлэн, танилаар нь дамжуулан тухайн кампанийн үйл ажиллагааны талаар эерэг агуулгатай нэвтрүүлгийг, төлбөртэй бэлтгэхийг хүссэн байна. Энэ бол тухайн асуудлыг олон нийтэд мэдээлэхгүй байх сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулж хэлбэр буй юм.


Дүгнэхэд, амь насанд халдахаар заналхийлэх нь аюулгүй байдлын хүнд хэлбэр гэж үзэж байна. Иймд, сэтгүүлч нь цахим заналхийлэл, сүрдүүлэг, дарамтад өртсөн тохиолдолд редакц, хүний эрхийг хамгаалах аливаа хэлбэрийн байгууллага, хууль хяналтын байгууллагад мэдэгдэхийг тэргүүнд тавьж зөрчил, аюул эрсдлийг бүртгүүлж байхыг зөвлөж байна.

3.3. Кейс шинжилгээ-2

Хоёрдахь кейс: Төрийн байгууллагын цензур, мэргэжлийн нэр хүнд рүү халдсан, эмэгтэй хүйсийн хувьд доромжилсон тохиолдол

Сэтгүүлч Б.Батцэцэг нь NTV телевизэд ажиллаж байхдаа “Тэгээс тэг” асуудал хөндсөн, эрэн сурвалжилсан нэвтрүүлгийн ээлжит дугаарыг “Зам дээр давс биш хужир цацсан учраас энэ жил замын гулгаа их байжээ” сэдвээр бэлтгэж, 2023 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр эфирээр олон нийтэд хүргэсэн. Сэтгүүлч нь НЗДТГ-ын Худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулахад шалгарсан “Мөнх Сонор Трейд” ХХК нь Төв аймгийн Бүрэн сумаас хужир тээвэрлэж буй асуудлыг сурвалжилсан. Энэхүү нэвтрүүлэг нь NTV телевизийн эфирт цацагдаж, Сэтгүүлч Б.Батцэцэг фэйсбүүк хуудсанд нэвтрүүлгийн хэсгээс болон юүтүб сувагт бүтэн байршсан.

Зураг 34. Кейс-2



Нэвтрүүлгийг бэлтгэж байх хугацаанд сэтгүүлчийн аюулгүй байдал нийт 6 удаа зөрчигдсөн.




Сэтгүүлч тухайн нэвтрүүлгийг бэлтгэж байхдаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазараас халтиргаа гулгаанаас сэргийлэх зорилгоор давс биш хужир цацаж байгааг тодруулга ярилцлага авах хүсэлтийг хэвлэлийн албанд гаргасан боловч мэдээлэл өгөөгүй, мэдээлэл өгөхөөс зайлсхийсэн байна. Нийтийн мэдээллийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл нь нээлттэй бөгөөд тус хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн байна.

Нэвтрүүлгийг эфирт цацахаас хэдэн цагийн өмнө төрийн байгууллагаас тодруулбал НЗДТГ-аас хувь хүн рүү /сэтгүүлч рүү/ дайрсан дарамт, сүрдүүлэг ирсэн. Энэ бол нэг төрлийн төрийн байгууллагын цензур юм.

Нэвтрүүлэг NTV телевизийн эфирт цацагдахаас өмнө нийгмийн мэдээллийн сүлжээнд сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүнд рүү халдсан постууд нийтлэгдсэн.


Нэвтрүүлгийн 8 минутын бичлэгтэй холбоотой нийт 1056 сэтгэгдлийн дийлэнх НЗДТГ-ийн талаарх сөрөг сэтгэгдэл болон олон нийтийн зүгээс үзэл бодлоо илэрхийлсэн байна. Сэтгүүлчийг эмэгтэй хүйсийнх хувьд доромжилсон сэтгэгдэл 1 байна. Энэхүү аккаунт нь жинхэнэ бөгөөд үндэсний бөх барилддаг эсвэл бөх сонирхогч хүн болох нь хувийн сошиал хуудсаас нь харагдана.

Зураг 36. Кейс-2. Нэвтрүүлгийн сэтгэгдлийн жишээ



хийх гээд байгаа бололтой гэж бичжээ”

Зураг 37. Кейс-2. Нэвтрүүлгийн сэтгэгдлийн жишээ



Тус хоёр сэтгэгдлийг бичсэн аккаунт руу нэвтрэхэд бодит хүмүүс бөгөөд цагдаагийн байгууллагыг илтгэх лого, постер зэргийг ашигласан нь анхаарал татна. Нийт сэтгэгдлийн дийлэнх нь НЗДТГ-ийн үйл ажиллагааны талаарх сөрөг болон давс, хужирны асуудлаар санаа бодлоо хуваалцсан олон нийтийн сэтгэгдэл байна. Мөн цөөнгүй хэдэн иргэнээс сэтгүүлчийн ажил хөдөлмөр, тухай нэвтрүүлгийг эерэгээр үнэлсэн байна.

Түүнчлэн нэвтрүүлэг цацагдсаны 11 хоногийн дараа буюу 2023 оны нэгдүгээр сарын 25-ний өдөр НЗДТГ-аас мэдээлэл хийсэн. Тухайн мэдэгдэлд цаашид зам дээр цацах давсыг нийслэлийн Хот тохижилтын газар хүлээн авахдаа шалгаж авахаар болсон тухай мэдэгдэв. Мөн зам дээр цацах давсны стандартгүй байсан бөгөөд ийм стандартай болох тухай мэдэгдсэн зэрэг эерэг үр дагавар авчирсан юм.

Энэ өдөр isee.mn сайт нь сэтгүүлчээс сурвалжилгыг хэрхэн бэлтгэсэн, мөн ямар дайралт, сүрдүүлэгт өртсөн тухай ярилцлага авсан. Сэтгүүлч хүний эрхийг хамгаалах төрийн, төрийн бус, олон улсын байгууллага, засгийн газрын харьяа байгууллага болон эрх бүхий хуулийн

байгууллагад дээрх аюулгүй байдлын зөрчлийн ямар нэгэн гомдол, өргөдөл гаргаагүй. Мөн редакцын зүгээс сэтгүүлчид эрсдэл, цензурээс хамгаалах талаар ямар нэгэн мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгөөгүй, үүний эсрэг хариу арга хэмжээ аваагүй.

Дээрх зөрчлүүдийг мэдээлээгүй шалтгааныг сэтгүүлчээс тодруулахад асуудал хөндсөн, эрэн сурвалжлах нэвтрүүлэг бэлтгэх үед цахим дайралт, сүрдүүлэг түгээмэл бөгөөд нэвтрүүлгийн үр дүн, дараагийн сурвалжлага бэлтгэхэд цаг хугацаа, анхаарлаа илүү хандуулдаг гэв. Мөн цахим, дайралт сүрдүүлэг бүрийг баримтжуулахад хугацаа шаарддаг, баримтжуулах явц нь сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг учир зөрчлийг мэдээлэхгүй өнгөрдөг хэмээв.

Дүгнэхэд, Сэтгүүлч Б.Батцэцэгийн фэйсбүүк хуудсанд нийтлэгдсэн нэвтрүүлэгтэй холбоотой бичлэгүүдийн нийт 1334 сэтгэгдлийг шүүж үзэхэд сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүнд рүү халдсан 2, эмэгтэй хүйсийн хувьд доромжилсон 1 сэтгэгдэл байна. Мөн нэвтрүүлэг бэлтгэж байх хугацаанд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учирч төрийн байгууллагаас мэдээлэл, хайх хүлээн авах эрхийг зөрчсөн төдийгүй хувь хүн рүү дайрсан мессеж, дуудлага сэтгүүлчид ирсэн. Энэ нь төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн бие даасан хараат бус байдалд нөлөөлж, цензур үүсгэх нэг хэлбэр байна.

3.4. Кейс шинжилгээ-3

Кейс 3: Сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүнд рүү халдсан тохиолдол

Сэтгүүлч С.Будрагчаа нь 2010 оноос хойш эрэн сурвалжлах сэтгүүлчээр ажиллаж байна. Түүний зарим эрэн сурвалжлах бүтээлээс дурдвал сэтгүүлч Б.Анхзултай хамтарсан УИХ-ын гишүүн асан, Содмонгол Группын ерөнхийлөгч Х.Анандбазар нь охид, эмэгтэйчүүдэд бэлгийн дарамт үзүүлсэн тухай эрэн сурвалжилсан цуврал бүтээлийг 2021 онд бэлтгэсэн. Тус нэвтрүүлгийг бэлтгэсний дараа түүний бие махбодийн болон цахим аюулгүй байдал алдагдаж сэтгүүлч Б.Анхзул, С.Будрагчаа нарт “бие махбодид халдахаар заналхийлэл, гүтгэлэг гүжирдэг, үл мэдэгдэх мессеж” ирж байсан байна.

Мөн сэтгүүлч С.Будрагчаа нь 2022 онд боловсролын салбар дахь авлигын асуудлыг хөндөж, Орос-Монголын хамтарсан сургуулийн захирал Ж.Соронзонг буруутгасан эрэн сурвалжилсан нэвтрүүлэг бэлтгэсэн. Сурвалжилгын дараагаар нэр дурьдагдсан удирдлага, түүний гэр бүлийнхэн болон тус сургуулийн зарим багш нарын зүгээс сэтгүүлчийн амь нас, түүний гэр бүлийг заналхийлсэн. Мөн цахим орчинд сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүндэд халдсан пост, сэтгэгдэл зэргийг зохион байгуулалттайгаар түгээж байв.


Сэтгүүлч С.Будрагчаа нь “Нууц материалууд” нэртэй баримт эрэн сурвалжлах нэвтрүүлгийг улирал бүр бэлтгэж 121000 дагагчтай “Budragchaa Serdamba” фэйсбүүк хуудсаар олон нийтэд нийтэд хүргэдэг.

2023-2024 онд түүний бэлтгэж олон нийтэд хүргэсэн нэвтрүүлгүүдийн сэтгэгдэл хэсгийг түүвэрлэн үзэхэд түүвэрт хамруулсан постуудын 1 орчим хувьд сөрөг дайралт, доромж үгс бичигджээ. Эдгээрээс дийлэнх нь сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүндэд халдсан байв.

Жишээ болгон Цемент шохойн ТӨХК-ийн ажилчид, удирдлага хоорондын хөдөлмөрийн маргааны асуудлыг 2023 оны дөрөвдүгээр сард сурвалжилсан цуврал нэвтрүүлэгт /2

сурвалжилга, 1 тодруулга ярилцлага/ анализ хийлээ. Budragchaa Serdamba фэйсбүүк хуудсанд нийтлэгдсэн тус цуврал нэвтрүүлгийн дундаж үзэлт 250 мянга орчим, нийт сэтгэгдэл 1600 гаруй тул зөвхөн сэтгэгдэл хэсгийг түүвэрлэн үзэв.

Зураг 38. Кейс-3



Зураг 39. Кейс-3. Сэтгэгдлүүд



“Нууц материалууд: Шахаа” нэвтрүүлгийг 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Budragchaa Serdamba хуудсаар 20 минут 30 секунд үргэлжлэхээр бэлтгэж, олон нийтэд хүргэсэн. Тус нэвтрүүлгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нь албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, "Цемент шохой" ТӨХК-ийн захирал Л.Наранбаатарт шахалт үзүүлэх замаар тус үйлдвэрийн удирдах албан тушаал дээр өөрийн багын найз болон нутгийн дүүгээ томилуулсан. Томилогдсон албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглаж, тус үйлдвэрийн цементийг их хэмжээгээр ченжид нийлүүлэх замаар цементийн үнэ бууруулах бодлого, аянг тасалдуулсан тухай нэвтрүүлэгт дурьджээ.

Энэхүү нэвтрүүлгийн үзэлт 457,000 үзэлт, реакшн 7100, сэтгэгдэл 1100 байна. Үүнээс нийт 970 сэтгэгдлийг шүүж үзэхэд дийлэнх нь нэвтрүүлгийн агуулгатай холбоотой бөгөөд төрийн өмчит кампанийн асуудлаар үзэгчид байр сууриа илэрхийлсэн байна. Түүнчлэн “шударга сэтгүүлч, мундаг, зөв асуудлыг

хөндсөн, мундаг сэтгүүлч, амжилт хүсье, ажлаа сайн хийгээрэй” гэсэн агуулгатай урам зориг өгсөн, дэмжсэн, эерэг сэтгэгдэл 4.5% байна. Харин сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүндийг илтэд гутаан доромжилсон коммент 1% байв. Жишээ нь: “шинэ цагийн шантаажчин, мөнгөний сэтгүүлч, худалдагсан, захиалгат нэвтрүүлэг, тархи угаагч, сэтгүүлчийн сэтэр зүүсэн, сэтгүүлчийн дүр эсгэсэн, авлигачин” гэх мэтээр бичжээ.


Энэхүү нэвтрүүлэг нь “Л.Наранбаатар: Сахал Эрдэнэбилэгийн санхүүгийн луйврыг би таслан зогсоосон” тодруулга ярилцлагаар 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр үргэлжилсэн. Тус нэвтрүүлэг нь 210,000 үзэлттэй, 3700 реакшинтай, 485 сэтгэгдэлтэй байна.

Зураг 40. Кейс-3. Нэвтрүүлэг



Нэвтрүүлгийн доорх коментуудад “Тутал долоогч, мөнгөний сэтгүүлч” гэсэн үгсээр сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүн рүү халдсан сэтгэгдэл 3 байх ба эдгээрийг нийтэлсэн Ганцэцэг Ганбат аккаунт руу нэвтрэхэд бодит зураггүй, зар сурталчилгааны болон цахим орчин дахь бусад мэдээллийг түгээдэг байна. Иймд тус хаягийн хуурамч хаяг үзэж болох юм.

Зураг 41. Кейс-3. Хувь хүний хаягийн жишээ



Сэтгүүлч
С.Будрагчаагийн
нэвтрүүлгийн 3 дахь
цувралыг “Сөрөг
тайлбар” нэртэйгээр 2023
оны дөрөвдүгээр сарын
28-нд 7 минут 51 секунд


үргэлжлэхээр бэлтгэж, Budragchaa Serdamba хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Тус нэвтрүүлгээр “Цемент шохой” төрийн өмчит компанийн зарим ажилчид, удирдлага Наранбаатарыг эсэргүүцсэн тэмцлийг сурвалжилсан. Нэвтрүүлэг нь 93, 000 үзэлттэй, 110 сэтгэгдэлтэй, 500 реакшинтай.

Зураг 42. Кейс-3. Нэвтрүүлгийн рейкиин жишээ



Сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүнд рүү “худалдагсан, мөнгөний сэтгүүлч, биеэ үнэлэгч” гэсэн үгсээр дайрч, халдсан сэтгэгдэл 5 байна. Үүнээс Ganbat Gangaa аккаунт руу нэвтрэхэд өөрийн зураггүй, найзын мэдээлэл байхгүй байна. Иймд энэ аккаунтыг хуурамч хаяг гэж үзэж байна .

Зураг 43. Кейс-3. Хувь хүний хаягийн жишээ



Дүгнэхэд, гурван цуврал нэвтрүүлгийн нийт 1695 сэтгэгдэлд анализ хийхэд 1 орчим хувь нь сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүндэд халдсан “худалдагдсан, мөнгөний сэтгүүлч, шантаажчин, долоогч” гэх мэт үгсээр дайрч, доромжилсон байна. Ийм сэтгэгдлүүдийг ихэвчлэн нэрээ нууцалсан хуурамч буюу өөрийн гэсэн зураг, оруулсан постгүй, социал орчинд дахь мэдээллүүдийг бусадтай хуваалцах төдийгүйгээр ашигладаг хаягнуудаас түгээж байна.

Бүлэг 4. Хууль, эрх зүйн орчны судалгаа

4.1. Хууль зүйн асуудал

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны Хүний эрхийг дээдэлсэн нийгэм бүтээх зорилгын хүрээнд 5.5.9-д "Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1. Хүний эрх, эрх чөлөө бүлгийн "4.1.2.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан, хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн Зорилт 3.4-т "Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ" гэж, 3.4.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно" гэж тус тус бодлого, хөтөлбөртөө тусгасан байна.

Сэтгүүлчдийн аюулгүй байдал бол хүний эрхийн чухал асуудал бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө өргөн хүрээнд эдлэхийн төвд нь оршдог. 2008 онд ЮНЕСКО-гийн МХХОУХ, Засгийн газар хоорондын Зөвлөлөөс баталсан "Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлт"-д сэтгүүлчдийн аюулгүй байдлыг үнэлэх богино боловч өргөн хүрээтэй шалгуур үзүүлэлтүүд орсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх. Мөн зүйлийн 17-д зааснаар төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй¹. Үндсэн хуулийн энэхүү заалтыг өргөтгөн баталгаажуулсан 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭОУП)-ыг Монгол улс 1974 онд соёрхон баталснаар үзэл бодолтой байх, үзэл бодлоо баримтлах, өөрчлөх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эсвэл илэрхийлэхгүй байх эрх чөлөөг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/-д үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн, хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад нэг алхам урагшилсан. Мөн Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт тооцохоор зохицуулсан. Тухайлбал, "Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын

¹ Монгол Улсын Үндсэн хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. (1992 он) №1

тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол...” гээд хүлээх хариуцлагад торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан байна. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн нэг тохиолдол байна. Тодруулбал, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.09.21-ний өдрийн 505 дугаартай шийтгэх тогтоолоор “Шүүгдэгч С.О нь 2019.03.25-ны өдөр Д телевизийн сэтгүүлч, редактор Ч.Д-ын 2017.03.17-ны өдөр Дундговь аймгийн Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулдаг Ч ХХК-ийн уурхайгаас бэлтгэсэн нэвтрүүлгээс өөрийн утсаар ярьж буй бичлэгийг гаргуулахгүй байхын тулд 2.500.000 төгрөг төлж зориуд нийтлүүлэхгүй байхаар завдсан” гэм буруутайд тооцож, 1.700.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн байна. Улсын Их хурлаас 2021.07.02-ны өдөр баталж 2021.07.06-ны өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.1-д зааснаар торгох ялыг өршөөн хэлтрүүлжээ. Мөн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн 2.500.000 төгрөгийг улсын орлого болгожээ. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн нэг тохиолдол хангалтгүй байна. Энэ нь дээрх гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах буюу тэднийг мэргэшүүлэх шаардлага байгаа болохыг харуулж байна. Эндээс үзэхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг Үндсэн хуулиас бусад хууль тогтоомжид үр дүнтэй баталгаажуулаагүй байна.

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд мэдээлэл дамжуулах, хүлээн авах, хэвлэн нийтлэх боломж хүрээ, хэлбэр улам бүр өргөжиж байна. Өнгөрсөн хугацаанд мэдээллийн сайтад хандах хандалтыг хязгаарлах, сайтыг хаах гэх мэт арга хэмжээ төрийн байгууллагын зүгээс авах нь нэлээд түгээмэл болсон. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөгч нь харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байна. Цаашлаад прокурорын зөвшөөрөл олгосон энэ үйлдэлд дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй² боловч үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлээр хууль тайлбарлах эрх бүхий “шүүх”-д гомдол гаргах боломжгүй. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлд заасан шүүхэд гомдол гаргах үндэслэлд хамаарахгүй. Ийнхүү үндсэн эрхээ хязгаарлагдаж буйг шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...” эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн байна.

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаархи гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана”.

4.2. Өнөөгийн нөхцөл байдал

2024 онд Глоб Интернэшнл төвөөс 386 сэтгүүлчийг хамруулсан Сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгаанд сэтгүүлчийн цахим аюулгүй байдалтай холбоотойгоор дараах байдлаар хариулсан байна. Үүнд, **утасны яриа чагнах, бичлэг хийх 16%, цахим шууданд халдах 15%, мэдээлэл хулгайлах 12%, техник технологид халдах /вирус тараах/ 9%, хувийн онлайн орон зайд халдаж, мөрдлөг хийх, хакдак 7%-ийг тус бүр эзэлж байна.** Мөн түүнчлэн, энэхүү судалгааны хүрээнд сүүлийн 12 сарын хугацаанд сэтгүүлчид хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн сүлжээний аккаунтаа хакердуулах тохиолдол гарсан уу гэж асуухад нийт судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн **55 хувь нь тийм**, эрх мэдэлтнүүд сэтгүүлчдийг хянах, тагнах чагнах үйл ажиллагаа явуулдаг уу гэхэд **41 хувь нь тийм** гэж хариулсан.

Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбогдон үүсэж болзошгүй эрүүгийн гэмт хэрэгт “Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх дамжуулах, тараах”³, “Худал мэдээлэл тараах”⁴, “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах”⁵, “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх”⁶, “Террорист үйлдлийн талаар зориуд мэдээлэх”⁷, “Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах”⁸, “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах”⁹ гэмт хэргүүд хамаарахаар байна. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбоотой эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс зайлсхийхийг НҮБ-аас гишүүн орнууддаа үүрэг болгосон байдаг. Энэхүү зарчмыг хуульд тодорхой тусган, Эрүүгийн хуулийг түүнд нийцүүлэх нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бодитой хамгаалах нөхцөл бүрдүүлэхэд томоохон алхам болно.¹⁰

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар сэтгүүлч нь хүний эрх хамгаалагчаар тооцогдсон нэг тохиолдол бүртгэгдсэн байна. Мөн 2021 онд УИХ-аас цахим аюулгүй байдлын багц хуулийг баталсан бөгөөд Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг зөвшөөрсөн юм.

Сэтгүүлчдийн аюулгүй байдлын өмнө нь хийгдсэн судалгаануудаас харахад, мэдээлэл хайх, хүлээн авахад хамгийн их саад бэрхшээл учирдаг тухай судалгаанд хамрагдсан сэтгүүлчид онцолдог байна.

³ Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйл

⁴ Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл

⁵ Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл

⁶ Эрүүгийн хуулийн 18.2 дугаар зүйл

⁷ Эрүүгийн хуулийн 20.1 дүгээр зүйл

⁸ Эрүүгийн хуулийн 20.2 дугаар зүйл

⁹ Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйл

¹⁰ The United Nations Human Rights Committee's General Comment No. 34 on Article 19 of the Inter-national Covenant on Civil and Political Rights (ICCPR) <<https://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>>

4.3. Сэдвийн судлагдсан байдал

Цахим орчин дахь сэтгүүлчийн аюулгүй байдлын эрх зүйн орчны асуудлаар нэг сэдэвт судалгааны бүтээл Монгол Улсад одоогоор хийгдээгүй байна. Харин хэвлэл мэдээллийн эрх зүй, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар судалсан дотоодын эрдэмтдийн бүтээл олноор хэвлэгджээ. Монгол Улсад хэвлэн нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах чиглэлээр дагнан ажилладаг Глоб Интернэшнл төвөөс боловсруулсан олон судалгаа, гарын авлага, тайлан бий. Тухайлбал, жил бүр хийгддэг сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүн болон 2019 онд Глоб Интернэшнл төв, Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, Монголын Хуульчдын холбоо байгууллагуудын хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг” нь энэ чиглэлээр хийгдсэн хамгийн сүүлийн үеийн судалгаа болж байна. Мөн түүнчлэн, 2022 онд ХЗДХЯ болон Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлсэн Иргэдийн оролцоо төслийн хүрээнд хуульч Л.Галбаатараар ахлуулсан “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн нөхцөл байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгаанд сэтгүүлчдийн аюулгүй байдалтай холбоотойгоор монгол улсын хэмжээнд гарсан 31 кэйсийг сонгон авч энэхүү судалгаандаа дурдсан¹¹ байна. Дээрх судалгаанаас Гурван сэтгүүлч тутмын хоёр нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байсан бөгөөд хамгийн түгээмэл хэлбэр нь утсаар заналхийлэх, эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг айлгаж, дарамтлах зэргээр илэрч байна. Сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлол гэх мэт зүйлд 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид илүү өртөж байгаа бол эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг болон гэр бүлийн гишүүдийг нь айлгаж, дарамтлах байдал эмэгтэй сэтгүүлчдэд илүү тохиолдож байна. Сэтгүүлчийн эсрэг тухайн зөрчлийг ноцтой биш, ямар нэг байдлаар их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үед зохих байгууллагуудад мэдэгддэггүй байна. Ихэнх тохиолдолд тухайн сэтгүүлчийн гэр бүлийн хүн, эсвэл ойр дотнын хүн нь түүнийг эрсдэлээс хамгаалж байна” гэж дүгнэлт гарсан байна.

¹¹ Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү. Л.Галбаатар, “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгааны тайлан. 2022 он. Иргэдийн оролцоо төсөл 129-142 дахь тал

Олон улсад сэтгүүлчдийн аюулгүй байдлыг бие махбодийн, дижитал болон сэтгэл зүйн гэсэн гурван түвшинд ангилан авч үзэж байна. Үүнд,

Хүснэгт 7. Сэтгүүлчийн аюулгүй байдлын тухай олон улсын ангилал

1	Бие махбодийн аюулгүй байдал	I. Эрсдэлийн үнэлгээ II. Нөхцөл байдлын талаарх мэдлэг ойлголт III. Төлөвлөгөө IV. Анхны тусламж үзүүлэх
2	Дижитал аюулгүй байдал	I. Дижитал-Физик хуваагдал II. Нийгмийн инженерчлэл III. Нууц үгээ хамгаалах IV. Компьютерийн аюулгүй байлгах V. Интернэт орчинд хэрхэн ажиллах VI. Вэб хөтчийн аюулгүй байдал VII. Ухаалаг утасны аюулгүй байдал
3	Сэтгэл зүйн аюулгүй байдал	I. Эрсдэлийн үнэлгээ II. Эрсдэлийг тодорхойлох III. Стресс менежмент IV. Өөртөө анхаарал хандуулах V. Нийгмийн сэтгэл зүйн байдал дахь анхны тусламж

4.4. Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчинг сайжруулах санал зөвлөмж

1/ Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотойгоор дараах байдлаар эрх зүйн орчинг сайжруулах

1.1. Сэтгүүлчийн аюулгүй байдал алдагдсан жишээ, баримттай харьцуулахад Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн 1 тохиолдол хангалтгүй байна. Мөн Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйл нь дан ганц хэвлэн нийтлэгчийн эрх, эрх чөлөөг хамгаалж байгаа тул олон ургалч үзэл санаа, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулах үүднээс “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн” бол хариуцлага хүлээлгэхээр нэмж оруулах;

1.2. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байж чадахгүй байна. Энэ нь сэтгүүлчийн эсрэг хүчирхийлэл болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдсан гэмт

хэргийг мөрдөн шалгах, яллах, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах, тэднийг мэргэшүүлэх;

1.3. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулж Эрүүгийн хуулиар шийтгэхгүй байх зарчмыг Эрүүгийн хуульдаа тусгах. Харин сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил маргааныг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр дамжуулан шийдвэрлэдэг байх;

1.4. Нийтийн мэдээллийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл нь нээлттэй тохиолдолд тус хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд тус хуульд заасан Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуулиар, харин хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг тухай бүрд нь хүлээлгэж байх;

1.5. Сэтгүүлчдийг нийгмийн сүлжээ, хувь чат, гар утсаар нь дамжуулан заналхийлдэг үйлдэлд Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.15 дугаар зүйл 1 дэх хэсэг Заналхийлэх гэмт хэрэгт холбогдуулан түргэн шуурхай шалгадаг байх;

1.6. Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, аливаа хэлбэрээр хүний эрхийг хамгаалах хэлбэрээр сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлчид нь ХЭҮК-ийн дэргэдэх Хүний эрх хамгаалагчийн хороонд гомдол, мэдээллээ гаргаж байх; (Хэрэв хүний эрх хамгаалагчаар тогтоогдсон тохиолдолд гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч байгаа аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг тодорхойлсон "эрсдэлийн үнэлгээ" хийгддэг.)

1.7. Мэдээллийн эх сурвалжийг Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулах шийдлийг оновчтой тусгах;

2/ Сэтгүүлчийн аюулгүй байдлыг бусад байдлаар хамгаалахтай холбоотойгоор сайжруулах

2.1. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд хиймэл оюун ухаан ашиглах талаар ёс зүйн заалтыг шинээр оруулах, редакцуудад таниулан сурталчлах;

2.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сэтгүүл зүйд тусгайлан тохируулсан хиймэл оюун ухааны хэрэглүүрүүдийг ашиглахтай холбоотой бодлогыг баталж, хэрэгжүүлэх;

2.3 Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор редакцууд сэтгүүлчдийн аюулгүй байдлын төлөвлөгөө /checklist/ баталж мөрдүүлэн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх;

5. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

Сэтгүүлчид ажил мэргэжилтэйгээ холбоотойгоор цахим орчинд дайралт, гутаан дорможлолд өртөх нь улам бүр нэмэгдэж байгаа ба дайралтын хэлбэр, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавар нь хувь хүн болон мэргэжлийн түвшинд ноцтой асуудал болох хэмжээнд хүрч байна.

Судалгааны үр дүнгээс харахад сэтгүүлчдийн бараг тал хувь нь цахим дайралтад өртөж байсан бөгөөд энэ нь ихэвчлэн гүтгэлэг, гутаан доромжлол, заналхийлэл хэлбэрээр илэрч байна. Илрэх хэлбэр, агуулгыг нарийвчлан харвал нас, хүйс, туршлага, ажиллаж буй салбаруудаас хамаарсан анхаарал татахуйц ялгаатай үр дүнгүүд ажиглагдлаа. Ялангуяа эмэгтэй сэтгүүлчид гадаад төрх, хувь хүний шинж чанартай холбоотой довтолгоонд илүү өртдөг бол эрэгтэй сэтгүүлчдийн хувьд мэргэжлийн нэр хүндэд нь халдсан, амь насанд заналхийлсэн тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад элбэг тохиолдож байна.

Цахим дайралтад өртсөн сэтгүүлчдийн зүгээс үзүүлж буй хариу арга хэмжээ нь мөн адил нас, хүйс, туршлагаас хамаарч ялгаатай байгаа нь илэрсэн ба энэ нь нөгөө талаас сэтгүүлчдийн ажлын туршлага, настай холбоотойгоор цахим дайралтын тухай мэдлэг ялгаатай байгааг харуулж байна. Ахмад насныхан голдуу сайн дурын байгууллагад хандах хандлагатай бол залуу сэтгүүлчид ийм тохиолдолд ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх нь түгээмэл байна.

Түүнчлэн сэтгүүлчид, хувь хүмүүсийн мэдлэг, ойлголт, хариу арга хэмжээнээс гадна тэдний ажиллаж буй байгууллага, редакцуудын зүгээс сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр тодорхой бодлого, арга хэмжээ хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа алхмуудыг цахим аюулгүй байдлын зохицуулалт болон урьдчилан сэргийлэлт талаас нь бүлэглэж авч үзвэл дараах ажлуудыг зөвлөж байна. Үүнд:

1. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:

-Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйлд "Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах" гэмт хэргийн хариуцлагыг тодорхой болгож, олон ургалч үзэл, редакцийн хараат бус байдлыг хамгаалах агуулга нэмэх.

-Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан "худал мэдээлэл тараах" гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй болгох чиглэлээр эрх бүхий байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх.

-Сэтгүүлчдийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хэрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульд тусгах.

-Сэтгүүлчид рүү чиглэсэн цахим заналхийлэл, дарамт шахалтыг Эрүүгийн хуулийн 13.15 дугаар зүйлд тусгаж, түргэн шуурхай шалгах механизмыг бүрдүүлэх.

-Сэтгүүлчид хүний эрхийн хамгаалалтын байгууллагад хандах боломжийг өргөжүүлэх, Хүний эрх хамгаалагчийн хороонд гомдол гаргах нөхцөлийг сайжруулах.

- Сэтгүүлчдийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан зөрчлийг хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр шийдвэрлэдэг практикийг эрх зүйн бодлогоор дэмжих.

-“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”, "Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль"-д сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулах.

2. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх чиглэлээр:

- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд хиймэл оюун ухаан ашиглах талаар ёс зүйн заалтыг шинээр тусгаж редакц, сэтгүүлчдэд таниулах сургалт хийх.

-Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сэтгүүл зүйн үйл ажиллагаанд зориулагдсан хиймэл оюун ухааны хэрэгслүүдийг ашиглах бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

-Сэтгүүлчдийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, тогтмол эрсдэлийн үнэлгээ хийх.

3. Сэтгүүлчдийн цахим дайралтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр:

-Сэтгүүлчдэд цахим дайралтаас сэргийлэх мэдлэг олгох, хариу арга хэмжээ авах чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг насны бүлгүүдийн онцлогт тохируулан зохион байгуулах.

-Хүйсийн ялгаатай байдал, жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой эрсдэлээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл олгох.

-Цахим орчны соёлыг сайжруулах, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр кампанит ажил зохион байгуулах.

Ашигласан материалын жагсаалт

А/ Монгол хэлээр

1. Б.Пүрэвсүрэн “Аюулгүй байдлаа хамгаал, амаа бүү үдүүл” нийтлэл, 2017 он <https://ikon.mn/opinion/2ddf>
2. Глоб Интернэшнл төв, Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, Монголын Хуульчдын холбоо “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг” 2019 он.
3. П. Эрдэнэжаргал, Д.Энхцэцэг, Б.Пүрэвсүрэн, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх санал”- Хуулийн шүүмж №46, Нээлттэй Нийгэм Форум, 2024 он. https://forum.mn/uploads/users/3092/files/OSF_Law%20review_46FINAL.pdf
4. Л.Галбаатар, “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгааны тайлан. 2022 он. Иргэдийн оролцоо төсөл.
5. Б.Баялагмаа, Э.Энхцэцэг, “Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг цахим хуудсыг хаах замаар хязгаарлах арга хэмжээний зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ”, 2025 он. Нээлттэй Нийгэм Форум
6. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
7. Монгол улсын Эрүүгийн хууль (2015)
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
9. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль (2021)
10. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (2021)
11. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021)

Б/ Гадаад хэлээр

1. The United Nations Human Rights Committee's General Comment No. 34 on Article 19 of the Inter-national Covenant on Civil and Political Rights (ICCPR)
2. Commission recommendation on ensuring the protection, safety and empowerment of journalists and other media professionals in the European Union 2021.
3. IREX, Safe Basic Training Curriculum, 2021.

Хавсралт 1. Санал асуулгын хуудас

Сэтгүүлчийн цахим аюулгүй байдлын мониторинг-2024

Энэхүү судалгааг сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг сайжруулах, хангах зорилгоор Хэвлэл Мэдээллийн Зөвлөл НҮТББ-аас явуулж байна. Сэтгүүлчийн ажил мэргэжилтэй холбоотойгоор **2020-2024** онд цахим орчинд ямар нэгэн **ДАЙРАЛТ** /заналхийлэл, сүрдүүлэг, дарамт, шахалт, доромжлол/-д өртөж байсан бол эсвэл өртсөн эсэхээ мэдэхгүй ч өртсөн гэж таамаглаж буй сэтгүүлч та энэхүү судалгаанд оролцож бидний ажилд дэмжлэг үзүүлэхийг хичээнгүйлэн хүсэж байна.

Тус судалгаанд оролцсноор сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарынханд нийтлэг тохиолдож буй кэйсүүдэд нарийвчилсан шинжилгээ хийхээс гадна сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг сайжруулахад хувь нэмэр оруулах болно.

Баярлалаа. Тус асуулгад хариулахад та дунджаар **16 минут** зарцуулах болно.

1. Таны нас? 1.18-25 2. 26-35 3.36-45 4. 46-55 5. 56+

2. Таны хүйс? 1. Эрэгтэй 2. Эмэгтэй 3. Бусад

3. Та хэвлэл мэдээллийн аль салбарт ажилладаг вэ?

1. Сонин 2. Радио 3. Телевиз 4.Мэдээллийн сайт 5.Чөлөөт сэтгүүлч

4. Таны ажлын туршлага

1. 1-3 жил 2.4-7 жил 3. 7-10 жил 4.10-15 жил 5. 15-20 жил 6.20-оос дээш жил

5. Та цахим дайралтын талаар мэдлэг, ойлголттой юу?

1. Сайн мэднэ 2.Тодорхой хэмжээнд мэднэ 3.Огт мэдэхгүй 4.Хэлж мэдэхгүй

6. Та цахим дайралт гэж юуг хэлж байгааг өөрийн бодлоор тодорхойлно уу? (Хэдэн ч хариулттай байж болно)

1. Цахим орчинд бусдаас заналхийлэл ирэхийг цахим дайралт гэнэ

2. Цахим орчинд бусад хүмүүс хэл амаар доромжилж, зүй бус үгээр харааж доромжлохыг цахим дайралт гэнэ.

3. Цахим орчинд бусад хүмүүс айлган сүрдүүлэхийг цахим дайралт гэнэ.

4. Дээрх бүх хэлбэрийг цахим дайралт гэнэ.

5. Хариулж мэдэхгүй байна.

6. Бусад.....
.....

7. Та 2020-2024 онд ямар нэгэн байдлаар цахим дайралтад өртсөн үү?

1. Тийм

2.Үгүй

3.Хэлж мэдэхгүй

8. Та 2020-2024 онд цахим дайралтад хэдэн удаа өртсөн бэ? (Хэрэв 7-р асуултад ҮГҮЙ гэж хариулсан бол 8-28-р асуултад хариулахгүй. 29-р асуултаас эхэлж хариулна)

1. 1-3 удаа
2. 4-6 удаа
3. 7-10 удаа
4. 10-аас дээш удаа
5. Хэлж мэдэхгүй
6. Энэ асуултад хариулахгүй

9. Цахим дайралтад өртсөн оныг тэмдэглэнэ үү?

1.2020 2.2021 3.2022 4.2023 5.2024

10. Дайралт ирсэн, өртсөн сувгийг сонгоно уу?/Хэдэн ч хариулт сонгож болно/

- 1.Фэйсбүүкийн пост 2. Фэйсбүүкийн чат
- 3.Инстаграм пост 4.Инстагрмын чат
5. Х жиргээ 6. Х чат 7.Viber чат
8. Гар утасны дуудлага 9. Гар утасны мессеж
- 10.Ажлын буюу албаны суурин утас 11.Цахим хаяг / И-мэйл
12. Энэ асуултад хариулахгүй
13. Бусад.....

11. Тухайн платформын эсрэг хариу арга хэмжээ авсан уу?

1. Тийм 2.Үгүй

12. Цахим дайралт хэнээс ирсэн бэ?

1. Засгийн газар, улс төрчдөөс
2. Бизнесмэн болон нөлөө бүхий этгээд
3. Урлаг, соёл, олны танил хүмүүсээс
4. Нийгмийн цөөнхөөс (Үндэсний цөөнх, ЛГБТ хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт)
5. Жирийн иргэдээс
6. Хэн гэдгийг нь тодорхой хэлж мэдэхгүй
7. Энэ асуултад хариулахгүй
8. Бусад.....

13. Цахим дайралт хэнээс ирснийг тодорхой мэдэж байвал нэрийг нь бичнэ үү (бичихээс татгалзаж болно)

.....
.....

14. Цахим дайралт газар зүйн байршлын хувьд хаанаас ирсэн бэ? (хэдэн ч хариулт сонгож болно)

1. Нийслэл / хотоос
2. Хөдөө орон нутгаас
3. Хаанаас гэдгийг нь тодорхой хэлж мэдэхгүй
4. Энэ асуултад хариулахгүй
5. Твиттер
6. Бусад.....

15. Доорх зөрчлийн хэлбэрүүдээс аль нь танд тохиолдож байсан бэ?

1. Амь насанд заналхийлсэн
2. Бие махбодид халдахаар заналхийлсэн
3. Бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхийг заналхийлсэн
4. Бэлгийн дарамт
5. Цахим халдлага
6. Гүтгэлэг, гүжирдлэг
7. Үл мэдэгдэх мессэж ирэх
8. Хувийн гэрэл зураг, дүрсийг зөвшөөрөлгүй тараах
9. Таныг тодотгох хувийн мэдээллээ алдах (Утас, гэрийн хаяг, нууц үг гэх мэт)
10. Тагнах, чагнах
11. Хуурамч сэтгэгдэл, реакшнуудаар дайрах
12. Үзэн ядсан, заналхийлсэн үг хэллэгээр дайрах
13. Энэ асуултад хариулахгүй
14. Бусад.....

16. Доорх цахим хүчирхийлэл, дайралтуудаас аль нь танд ирсэн бэ?

1. Заналхийлэл: Амь насанд халдах дайралт
2. Заналхийлэл: Бэлгийн хүчирхийллийн дайралт
3. Заналхийлэл: Бие махбодид халдах дайралт
4. Заналхийлэл: Гэр бүл, ойр дотны хүрээлэлд нь халдах дайралт
5. Мэргэжлийн нэр хүндэд халдах
6. Хувь хүн рүү дайрах: Хүйсээр ялгаварлан гадуурхах, ялангуяа зөвхөн эмэгтэй хүн гэдгээр нь дайрах, доромжлох
7. Хувь хүн рүү дайрах: Ил тодоор садар самуун, бэлгийн шинж чанартай үг, хэллэг, зураг ашиглах
8. Хувь хүн рүү дайрах: Арьс өнгө, үндэс угсаагаар нь ялгаварлах
9. Хувь хүн рүү дайрах: Ижил хүйстэн гэж доромжлох
10. Хувь хүн рүү дайрах: Бусад төрлийн хараалын үг зэргээр дайрах, доромжлох
11. Илтгэл үнэмшил рүү дайрах: Шашин, шүтлэг
12. Илтгэл үнэмшил рүү дайрах: Улс төрийн үзэл баримтлал гэх мэт
13. Энэ асуултад хариулахгүй
14. Бусад.....

17. Цахим хүчирхийлэл, дайралтад өртсөнөө ямар нэгэн байдлаар баримтжуулж чадсан уу?

1.Тийм 2.Үгүй 3.Санахгүй байна 4.Энэ асуултад хариулахгүй

18. Цахим хүчирхийлэл, дайралттай холбоотой нэмэлт мэдээлэл байгаа бол энд бичнэ үү (Хаштаг хэрэглэсэн эсэх, утас, э-мэйл болон бусад хэлбэрээр дарамталсан эсэх тухай гэх гэх мэт)

.....

19. Цахим хүчирхийлэл, дайралт хүчирхийллийн агуулгыг товч тайлбарлана уу?

.....

20.Та тухайн цахим дайралтын бодит нөхцлийн эрсдлийг үнэлнэ үү!

№		Өндөр	Дунд	Бага	Мэдэхгүй
1	Сэтгэл санаа, бие махбодын эрсдэл	1	2	3	4
2	Эдийн засгийн эрсдэл	1	2	3	4
3	Гэр бүлд нөлөөлсөн эрсдэл	1	2	3	4
4	Найз, нөхдөд ирсэн эрсдэл	1	2	3	4
5	Бусад эрсдэл.....	1	2	3	4

21. Бусад эрсдэл байгаа бол бичнэ үү?

.....

22. Тухайн дайралт танд ямар нөлөө үзүүлсэн тухай бичнэ үү (Сэтгэл санаа, эдийн засаг)

.....

22/1 Сэтгэл санаа бие махбодын нөлөөллийг бичнэ үү?

.....

22/2 Эдийн засгийн нөлөөллийг бичнэ үү?

.....
.....
.....

22/3 Гэрл бүлд нөлөөлсөн нөлөөллийг бичнэ үү?

.....
.....
.....

22/4 Найз нөхдөөс ирсэн нөлөөллийг бичнэ үү?

.....
.....
.....

22/5 Бусад төрлийн нөлөөлөл байсан бол бичнэ үү?

.....
.....
.....

23. Хуулийн арга хэмжээ авсан уу?

1.Тийм

2.Үгүй

3. Энэ асуултад хариулахгүй

24. Тийм бол ямар нэгэн арга хэмжээ авсан уу? (Гурав хүртэлх хариултыг сонгож болно)

1. Хуулийн байгууллагад хандсан / Засгийн газрын харъяа байгууллага

2. Редакц, удирдлагадаа хандсан

3. Өмгөөлөгчид хандсан

4. Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлд хандсан

5.Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах ямар нэгэн сайн дурын байгууллагад хандсан

6. Найз нөхөд, гэр бүл ойр дотны хүнд хандсан

7.Бусад.....

.....

25. Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах ямар нэгэн САЙН ДУРЫН БАЙГУУЛЛАГАД хандсан бол хэзээ, ханаа хандсан бэ?

Хэзээ:

Хаана:

26.Засгийн газрын харьяа байгууллагад хандсан бол ХЭЗЭЭ, ХААНА хандсан бэ?

Хэзээ:

Хаана:

27.Цахим дайралтын дараах тусламж, үйлчилгээ дэмжлэгийг авсан уу?

- 1.Аюулгүй байдлын тухай сургалт, зөвлөмж
2. Сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээ
3. Бусад зөвлөмж үйлчилгээг авсан (Бусад гэдэг агуулгыг сонгосон бол тодруулж бичнэ үү)
4. Ямар ч зөвлөмж үйлчилгээ аваагүй.
5. Санахгүй байна
6. Энэ асуултад хариулахгүй

28.Бусад зөвлөмж үйлчилгээг авсан бол тодруулж бичнэ үү?

.....
.....
.....

29. Та сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өөрийгөө цензурдаж байсан уу?

- 1.Тийм 2.Үгүй 3.Хэлж мэдэхгүй байна

30. Хэрэв тийм бол “Өөрийн цензур” ямар шинжээр илэрсэн бэ? (Тав хүртэлх хариултыг сонгож болно)

- 1.Эрхлэгч, редактороос зэмлэл, шүүмжлэл ирнэ гэж бодсон
- 2.Цалин, урамшуулал хасна гэж бодсон
- 3.Хамтран ажиллагсдаас зэмлэл, шүүмжлэл ирнэ гэж эмээсэн
- 4.Эздээс дарамт, шахалт, хүсэлт ирнэ гэж бодсон
5. Үзэгч, уншигчдаас зэмлэл, шүүмжлэл ирнэ гэж бодсон
- 6.Бусад.....

**31.Таны бодлоор “Өөрийн цензур”-ын хамгийн нийтлэг хортой үр дагавар юу вэ?
(Нийтлэг тохиолддог эсвэл тохиолдож болзошгүй 3 хүртэлх хариултыг сонгоно уу)**

1. Ирээдүйдээ итгэл алдарч сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулахаас татгалзаж эс үйлдэхүйд хөтөлнө
2. Олон нийтийн ашиг сонирхлыг хойш тавина
3. Онц ач холбогдолгүй, нийтийн ашиг сонирхлоос ангид хөнгөн мэдээлэл рүү шилжинэ
4. Сэтгүүлчийн ур чадвар, зориг мөхнө
5. Редакцын хамтын ажиллагаа суларч чанартай бүтээл цөөрнө
6. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа хийхээс татгалзаж ажлаа орхино
7. Сэтгүүлчийг гэмт хэрэгт буруутгаснаар аюул заналыг өөрт хамаатуулна
8. Эрэн сурвалжилсан бүтээл хийхээс татгалзана
- 9.Бусад

32.Цаашид сэтгүүлчийн цахим аюулгүй байдлыг хамгаалах, сэтгүүлчийн өөрийн цензурыг бууруулахтай холбоотой чухал гэсэн ГУРВАН саналаа үлдээнэ үү.

- 32.1.....
.....
.....
- 32.2.....
.....
.....
- 32.3.....
.....
.....

Судалгаанд оролцсонд баярлалаа!

Судалгааны асуулгатай холбоотой нэмэлт мэдээллийг тодруулах тохиолдолд тантай утсаар холбогдоно. Та утасныхаа дугаарыг үлдээхийг хүсье!

Утасны дугаар: